

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.01.05.

Арвайхээр.

Тус Цагдаагийн газрын алба хаагчид нь Цагдаагийн ерөнхий газраас 2017 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, ЦЕГ-ын дарга удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, үр дүнгийн гэрээнд тусгуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж албан даалгавар, үүрэг чиглэлүүдийн заалт бүрийг ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, биелэлтийг тооцон Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Хуулийн хэлтэс, Хүний нөөц сургалтын хэлтэс, Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын “Бүтээлч Өвөрхангай” мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Цагдаагийн ерөнхий газраас 2017 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цагдаагийн газраас “2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Сургалтын төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”, “Дотоод аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө”, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамж төлөвлөгөө”, “Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө” зэрэг баримт бичгүүдийг батлан гаргаж хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нар т хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Цагдаагийн ерөнхий газрын даргын төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, ажлын чиглэлийг бие бүрэлдэхүүнд танилцуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, биелэлт үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж биелэлтийг тооцон ажилласан.

Цагдаагийн газрын 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө, хэлтэс, тасаг хэсгээс хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гаргаж газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа албад, бусад байгууллагуудад 4670 албан бичиг, тоотыг хүргүүлж, бусад газраас ирүүлсэн 5313 албан бичгийг хүлээн авч, биелэлт тооцох 990 албан бичгийн биелэлтийг тооцон хариуг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тухай бүр бие бүрэлдэхүүнд танилцуулж, цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 21 удаа хийж, үйл ажиллагааны талаар 191

тушаал гаргаж холбогдох асуудлыг шийдвэрлэв.

Тасгуудаас сургагч багш нарыг сонгон тушаалаар томилж шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийг бүлэг бүрээр сургагч багш нар алба хаагчдад сургалт зохион байгуулсан ба шинээр батлагдан гарсан журмуудыг тухай бүр бие бүрэлдэхүүнд мэдээлж сургалт зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайланг 2017 оны 12 дугаар сарын 24-ний өдөр аймгийн тамгийн газарт иргэний зөвлөлд тайлагнасан.

Алба хаагч солилцооны хүрээнд замын цагдаагийн 2 алба хаагч Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэст, хэв журмын ахлах байцаагч, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажил хариуцсан ахлах мөрдөгч нар Хэнтий аймаг дахь цагдаагийн газарт туршлага судалж ажилласан.

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа албад, цагдаагийн газрын дарга нараас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 тушаал, журам, заавар, 27 үүрэг, чиглэл, зааварчилга өгч, 31 буюу 91.0 хувьд нь биелэлт үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас нэгтгэн ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүгнэлт хийн аймгийн эрүүгийн болон хэв журмын харьцуулсан мэдээ, сумдад бүртгэгдсэн хэргийн судалгааг гарган аймгийн засаг дарга, ИТХ-ын дарга нарт сар бүр хүргүүлж ажилласан.

Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулгыг 7 хоног тутмын 1 дэхь өдрийн өглөөний рапортоор бие бүрэлдэхүүнд танилцуулан, танилцуулгын хувийг тасгийн дарга нарт, 2 дахь өдөр бүр аймгийн шуурхай зөвлөгөөн, аймгийн засаг дарга, ИТХ-ын дарга нарт хүргүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын санаачилгаар 7 дугаар сараас эхлэн Арвайхээр хотоос зүүн тийш 5 километр зайд 2 га газар авч “Сургалтын төв” барих ажлыг эхлүүлж тус бүр нь 7.5 сая төгрөгний өртөгтэй 5 ширхэг амралтын байр барьж цахилгааны асуудлыг шийдвэрлэн, блокон суурьтай төмөр хийц бүхийн 670 метр урт хашаа барьж ашиглалтанд оруулав.

Аймгийн Засаг даргын "Хөрөнгө акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх тухай А/328 захирамжаар сумдын Эрүүл мэндийн төвүүдээс актлагдсан автомашинуудыг хүлээн авч 2017 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэсгийн төлөөлөгч нарт хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ зохион байгуулж цагдаагийн ахмад ажилтнуудаа урьж оролцуулсан. "Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн Зооноз судлалын төвтэй хамтран алба хаагчдыг тарваган тахлын эсрэг вакцинд хамруулсан.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас Цагдаагийн газарт ажиллаж байгаа 40-өөс дээш насны алба хаагчдыг элэгний В, С вирусын үзлэг, шинжилгээнд хамруулсан.

“Оюунлаг цагдаа-1” “Оюунлаг цагдаа-2” арга хэмжээг зохион явуулж, ном хандивласан алба хаагчдыг шалгаруулж өргөмжлөл, удирдамжинд заасан цалингийн тодорхой хувиар 9 алба хаагчийг урамшуулсан, арга хэмжээний хүрээнд 325 номтой болж 43 алба хаагчид бүртгэлээр ном уншиж байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 20 хувийн хөнгөлөлттэй 20.000 төгрөгөөр 2017 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн БОЭТөвд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэгдсэн үзлэгт 16 алба хаагчыг сайн дурын үндсэн дээр хамруулав.

Цагдаагийн газрын хэмжээнд нийт 39 ахмад настан харьяалагдаж байгаа бөгөөд цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Бат-Очирыг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Содномцэрэнг “Алтан гадас” одонгоор, цагдаагийн бэлтгэл ахмад С.Александр, цагдаагийн бэлтгэл ахмад

Б.Готовсүрэн нарыг “Цэргийн хүндэт медаль”-аар шагнуулах санал, тодорхойлолтыг аймгийн ИТХТ-ийн даргын нэр дээр албан бичгээр хүргүүлэв. Цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Бат-Очирыг ЦЕГ-ын “Цагдаагийн төлөө” тэмдэг, ЦЕГ-ын дэргэдэх Цагдаагийн ахмадын байгууллагын “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнуулсан.

Аймгийн Засаг даргатай Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Хамтран ажиллах гэрээ”-нд хэсгийн төлөөлөгч нарын гэр бүлийг ажлын байр бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр саналыг хүргүүлж гэрээнд тусгуулсан.

Хужирт суманд цагдаагийн хэсгийн кобан байр бариулах саналыг аймгийн Засаг дарга болон тус аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдэд хүргүүлээд байна.

“Ахмад настнуудыг дэмжих” жилийн ажлын хүрээнд тус байгууллагаас төрөн гарсан Монгол Улсын гавьяат цолтон, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, “Ахмад, дунд, залуу үеийн уулзалт зөвлөгөөн”-ийг зохион байгуулахад аймгаас 3 сая төгрөгийг шийдвэрлэж 2017 оны 09 дүгээр сарын 20-оос 23-ны өдрүүдэд цагдаагийн газарт зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгуудын эрүүгийн цагдаагийн алба хаагч нарыг хамруулсан “Бүсчилсэн сургалт”-ыг 09 дүгээр сарын 25-аас 30-ны хооронд зохион байгуулж “сайн” үнэлгээг авсан.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор цагдаагийн газраас ажлын хэсгийг томилон 2017 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын хэвлэл мэдээллийн төв дээр ажиллалаа. Энэ ажлын хүрээнд төвийн үйл ажиллагаатай танилцаж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар туршлага судлан 4 төрлийн ажил арга хэмжээг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн төлөвлөгөөнд алба хаагчдаас шинэ санал санаачилга гаргаж ажиллах талаар тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал цаашид Цагдаагийн газраас авч хэрэгжүүлэх тодорхой ажлуудын талаар Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын дэргэдэх шуурхай хуралдаанд шат дараатайгаар мэдээлэл хийж санал солилцон ажиллаж байна.

2017 оны томоохон ажлуудын нэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлуулж, үр дүнг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх” чиглэлээр Хууль Сахиулахын Их Сургуулийн Криминологи судалгаа, мөрдөх албаны тэнхимтэй хамтран ажиллаж байна. Судалгааны зорилго нь Монгол Улсын Их хурлаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд суурь хуулиуд шинэчлэн баталсантай холбогдуулж, Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг криминологийн шинжлэх ухааны үүднээс үнэлж, дүгнэн цаашид орон нутгийн хэмжээнд шинжлэх ухааны үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Судалгааны ажлын хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралд Хууль сахиулахын Их сургуулийн мөрдөх албаны тэнхимийн багш Л.Цогтбаяр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн судлаачид хүрэлцэн ирж, судалгааны ажлын явцын тайлан, 32 заалт бүхий зөвлөмжийг танилцуулсан.

Энэхүү судалгааны ажил хийгдсэнээр гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс шинжлэх ухааны үр дүнд бодиттой тодорхойлогдож, санал,

зөвлөмж бүхий судалгааны тайлан боловсруулагдан, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бодит ахиц гарах үр дүнтэй юм.

Мөн Өвөрхангайчуудын санал, санаачлагыг тусгасан “Таны санал-төрийн шийдвэрт” харилцах дэвтэрийг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд аймгийн 19 сум, 109 баг, Арвайхээр хотын төр, захиргаа, хувийн хэвшлийн 82 байгууллагад 300 дэвтрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумдын ГХУСАЗ салбар зөвлөлтэй хамтран аялуулж 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс сумд, байгууллагуудаас татан төвлөрүүлж дэвтэрт ирүүлсэн саналыг нэгтгэхэд давхардсан тоогоор 13.500 иргэнээс 9054 санал бичигдсэнээс хамгийн олон удаагийн давтамжтай ирүүлсэн эхний 10 саналыг эрэмбэлэн гаргаж, аймгийн ИТХурал, Засаг дарга нарт танилцуулсан. Дээрх криминологи судалгааны дүгнэлт, харилцах дэвтрээр ирүүлсэн иргэдийн саналыг үндэслэн 2018 онд “Аюулгүй иргэн амар тайван Өвөрхангай” хөтөлбөр хэрэгжүүлэхээр төслийг 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ГХУСАЗЗөвлөлд танилцуулж, 2018-2020 он хүртэлх хугацаанд “Аюулгүй иргэн-амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлуллаа.

Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл шалгалтыг эрчимжүүлэн, эргүүл шалгалтанд гарч буй алба хаагч нарт тавих хяналтыг сайжруулан томилгоот дарга, ёс журам сахиулах эргүүлийг томилон, үйл ажиллагааг зурагжуулан баримтжуулж сурвалжлагч ажиллуулж байна.

Алба хаагч нарын мэдээ өгөх байдлыг нэгдсэн системд оруулан, чиглэл чиглэлээр хаалттай Facebook групп нээж алба хаагч нарт хариуцуулан мэдээг авч Facebook групп-т байршуулан, алба хаагч нарыг А-Ф үнэлгээгээр үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн цагдаагийн газрын даргын тушаалаар аймгийн төвд 24 цагаар хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж эхлээд байна.

Аймгийн засаг даргын 2017 оны А/388 дугаар захирамжийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар баг “Шинэ Арвайхээр” сууршилийн бүсэд 3000 метр квадрат газрыг цагдаагийн газрын оффисын зориулалтаар газар эзэмших эрхийг авч “НГ” ХХК-р Цагдаагийн газрын оффисын барилгын зураг төсвийг 45 сая төгрөгөөр хийлгэхээр шийдвэрлэн “Ленд Тест” ХХК-р Цагдаагийн газрын оффисын зориулалттай барилгын талбайн инженер-гидрогеологийн судалгааны дүгнэлтийг гаргуулсан.

Хужирт сум дахь Цагдаагийн тасгийн кабон байрны зориулалттай 400 метр квадрат талбайн гэрчилгээг гаргуулан барилгын зураг төсвийн гэрээг “НГ” ХХК, Хужирт сумын засаг дарга Р.Лхагвасүрэн, Цагдаагийн газрын дарга нарын гурвалсан гэрээг 15.000.000 төгрөгөөр байгуулан “Ленд Тест” ХХК-р кабон байрны барилгын талбайн инженер-геологийн судалгааны дүгнэлтийг 1 сая төгрөгөөр гаргуулан ажиллав. “НГ” ХХК-р Онгийн голын гүүрэн дээр баригдах замын цагдаагийн хяналтын постны зураг төсвийг хийлгэн “Ленд Тест” ХХК-р барилгын талбайн инженер-гидрогеологийн судалгааны дүгнэлтийг 500.000 төгрөгөөр гаргуулан ажилласан.

Арвайхээр сумын багийн иргэдийн нийтийн хурлын нэгдсэн хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийж Өвөрхангай аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2018 онд хийгдэх төсвийн зарцуулалтын хүрээнд Арвайхээр сумыг бүрэн камержуулах ажлыг 1 дүгээрт эрэмбэлүүлж 640.000.000 сая төгрөгний үнэ бүхий камер, гэрэлтүүлэг шинээр суурилуулахаар болсон.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Арвайхээр суманд 3, Баян-Өндөр суманд-1, Хархорин суманд-1 согтуурал хэмжигч драгер багжийг шийвэрлүүлэн, бусад сумдад драгер багаж шийдвэрлүүлэхээр саналыг сумдын удирдлагуудад хүргүүлэн ажилласан.

Алба хаагчдын шагнал урамшуулал, албан тушаал дэвшүүлэхэд сахилгын

шийтгэлтэй эсэх, үр дүнгийн гэрээний биелэлт дүгнэгдсэн эсэх байдлыг гол шалгуур үзүүлэлт болгон ажиллаж байна. Тус Цагдаагийн газраас 2017 онд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлын хангах хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Мягмарсүрэн, Архидан согтуурахтай тэмцэх ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Р.Амаржаргал, Баян-Өндөр сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч Б.Цогтбаяр нар “Цэргийн хүндэт медаль”-аар, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Бүрэнтөгс “Цагдаагийн алдар” тэмдэгээр, Баруунбаян-Улаан сумын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ж.Отгонбаатар, Зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Бямбацэрэн, хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч Б.Цогтбаяр, цагдаагийн дэслэгч А.Ганбаатар нарыг ЦЕГ-ын “Цагдаагийн гавъяа тэмдэг”-ээр, цагдаагийн ахмад Ч.Отгонжаргал, мөрдөгч, цагдаагийн ахмад Д.Бямбабат, цагдаа-зохицуулагч цагдаагийн дэд ахлагч П.Ганбаатар, харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Мягмарсүрэн нарыг ЦЕГ-ын “Баярын бичиг”-ээр, цагдаагийн ахлах дэслэгч А.Даваадэмбэрэл ХБА-ны “Баярын бичиг”-ээр, цагдаагийн ахлах ахлагч А.Хишигт “Сургагч ахлагч” цолоор, цагдаагийн хурандаа О.Ганбат, цагдаагийн ахмад Ж.Мягмар ЦЕГ-ын “Хүндэт жуух”, хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ц.Бээжин, цагдаагийн дэслэгч Ц.Самдантүвдэн ЦЕГ-ын “Спортын алдар”, цагдаагийн хошууч Ч.Алтанхүү ЦЕГ-ын МНБГ-ын “Статистикын тэргүүний ажилтан”, цагдаагийн хошууч Б.Цогтбаяр аймгийн засаг даргын “Хүндэт жуух”, цагдаагийн дэд ахлагч У.Мягмарнасан аймгийн засаг даргын “Хүндэт жуух”, цагдаагийн ахмад Д.Бямбабат аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын “Жуух бичиг”, цагдаагийн ахлах ахлагч Б.Батнасан Арвайхээр сумын ИТХ-ын “Хүндэт жуух”, цагдаагийн ахлах ахлагч Б.Нэргүй МНБГ-ын “Баярын бичиг”, цагдаагийн ахлах дэслэгч Л.Адьяатөмөр, цагдаагийн дэд ахлагч С.Бадамсүрэн МЗХ-ны “Цэргийн алдар”, цагдаагийн дэд ахлагч Б.Ууганбаяр, цагдаагийн дэд ахлагч П.Ганбаатар МЗХ-ны “Эр зоригийн алдар”, цагдаагийн дэд ахлагч А.Ганзориг, цагдаагийн дэслэгч Ц.Бээжин, цагдаагийн ахлагч Г.Чулуунбаяр, цагдаагийн ахлах дэслэгч Н.Лхагвасүрэн, цагдаагийн дэд ахлагч, Р.Цэрэнлхагва, цагдаагийн хошууч Б.Мөнх-Эрдэнэ, цагдаагийн ахлах дэслэгч Э.Өлзийжаргал, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Амартүвшин ЦГ-ын “Баярын бичиг”, албаны төлөө 1, 2, 3 тэмдэгээр 30 алба хаагч шагнуулсан байна.

Цагдаагийн ахмад Г.Уранбат Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Санчир Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагчаар, цагдаагийн хошууч Д.Отгонбаяр Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах хэсгийн даргаар, цагдаагийн хошууч Ч.Дэлгэрнасан Бат-Өлзий сум дахь цагдаагийн хэсгийн даргаар, цагдаагийн дэд хурандаа А.Мөнхтөр Хэрэг бүртгэх тасгийн даргаар тус тус дэвшин, цагдаагийн ахлах ахлагч А.Ганбаатар, Д.Пүрэвдорж, Б.Довчинцэрэн, Д.Батбаяр, цагдаагийн ахлагч И.Бадрахзул, цагдаагийн дэд ахлагч Г.Төгөлдөр нар офицерын бүрэлдэхүүнд орж, хэсгийн төлөөлөгч, мөрдөгч, жижүүрийн офицер албан тушаалд томилогдон, нийт 43 алба хаагч албан тушаал /ажлын байр/ өөрчлөгдөж, 21 иргэнийг албан тушаал /ажлын байр/-д шинээр томилж, 9 алба хаагч шилжиж ирж 13 алба хаагч шилжсэн байна.

Төрийн тусгай албан тушаалын сул орон тоог нөхөх ажлын байрны захиалгыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж, цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн 11 иргэнийг судлан, төрийн тусгай албан тушаалын сонгон шалгаруулалтад хамруулж, 7 иргэн албан тушаалд томилогдож, ахлагчийн сургалтад 5 иргэн суралцаж байна.

2016 онд 3 гэмт хэрэгт 5 албан хаагч холбогдож 30 албан хаагч сахилгын арга хэмжээ тооцогдсон бол 2017 онд 1 гэмт хэрэгт 1 алба хаагч холбогдон шалгагдаж, 36 албан хаагч сахилгын арга хэмжээ авагдсан байна. Цагдаагийн газрын 36 алба хаагч

сахилгын зөрчил гаргасан нь өмнөх оны мөн үеэс сахилгын зөрчлийн тоо 6 буюу +16.6 хувиар, зөрчил гаргасан офицер 5 буюу +20.8 хувиар, ахлагч 1 буюу +8.3 хувиар тус тус өссөн байна.

Сахилгын шийтгэлийн мэдээг хувийн хэрэг болон “Хүний нөөцийн цахим систем”-д тухай бүр буюу шагнагдсан 67, цол шагнагдсан 28, албан тушаал /ажлын байр/ өөрчлөгдсөн 52, шинээр томилогдсон 21, шилжиж ирсэн 9, шилжсэн 13, ажлаас халагдсан 1, тэтгэвэрт гарсан 4, ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 6, сахилгын шийтгэл оногдуулсан 36 алба хаагчийн мэдээллийг цаг тухайд нь оруулж, баяжилт хийж ажиллалаа.

2017 онд цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан хэлбэр, хэмжээг харгалзан шат дараалсан сахилгын шийтгэл оногдуулах зарчим баримтлан нийт 36 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулснаас 4 алба хаагчид Цагдаагийн ерөнхий газрын даргын, 32 алба хаагчид байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан байна.

2016 онд нийт 30 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдснаас 19 буюу 63.3 хувийг офицер, 11 буюу 36.1 хувийг ахлагч, 2017 онд нийт 36 алба хаагчаас 24 буюу 66.6 хувийг офицер, 12 буюу 33.3 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна. Эндээс офицерын манлайлал хангалтгүй байгааг харуулж байна.

ЗЦТ ижил түвшинд, МБТ 3-аар буюу +33.3 хувь, ЭЦТ 4-өөр буюу +36.6 хувь, НХЖХТ 3-аар буюу + 33.3 хувиар өссөн, ЗУТ 1-ээр буюу -50 хувиар, Хархорин сумын сум дундын Цагдаагийн хэлтэс 4-өөр буюу -36.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч нарт “Итгэл найдварын хуудас” гардуулан өгч, баталгаа гаргуулан авч ажиллалаа.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагч бүрт тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудаас хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу алба хаагч тус бүртэй ажиллаж, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлаж, 3 хэсгийн төлөөлөгчийн ар гэрийн холбогдох хүмүүстэй уулзаж, сум орон нутгийн удирдлагаас хэрхэн ажил үүрэг гүйцэтгэж байгаа талаар, сар бүр цагийн тооцоог гаргуулан авч, бусад алба хаагчдын хувьд тасгийн дарга ахлах албан тушаалтан, бусад тасаг, хэсгийн зүгээс хамтран ажиллах, сэтгэл зүйчээс гаргасан төлөвлөгөөний хүрээнд сэтгэл зүйн тандалт судалгаа явуулж тодорхой ажил, сургалтыг зохион байгуулж байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдаас 6 алба хаагчийг ёс зүйн төлбөртэй сургалтад ЦЕГ-ын Сургалт дадлагын төвд хамруулаад байна. Ажлын зайлшгүй шаардлага, алба хаагчдын өөрсдийн санал хүсэлтийн дагуу 29 ахлагч албан тушаалтны албан тушаал /ажлын байр/-г өөрчлөн, шинээр ахлагч албан тушаалд 9 иргэнийг томилсон.

Гэмт хэрэгт өртөж хохирсон алба хаагчийн талаар: Албан үүргээ гүйцэтгэж яваад 1 алба хаагч эрүүгийн гэмт хэрэгт өртөж хохирон 500.000 /Таван зуун мянган/ төгрөгний хохирол учирсныг нөхөн төлүүлж, 8 алба хаагч захиргааны зөрчил гарган торгуулж, 6 алба хаагч захиргааны зөрчилд өртөж хохирсон бөгөөд цагдаагийн албан хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцсэн 6 этгээдэд баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Шинээр томилогдсон 21 алба хаагчид захиргааны зөрчил шийдвэрлэх кодыг олгуулсан. Цагдаагийн газарт ажиллаж байгаа 89 ахлагчийн хувийн хэргийн баяжилтийг цаг тухайд нь хийж, офицер алба хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийх материалыг улирал тутам Хүний нөөц, сургалтын хэлтэст бүртгэл хөтлөн хүргүүлэв. 2017 онд Цагдаагийн газрын даргын тушаалаар халагдсан, чөлөөлөгдсөн 6 ахлагч, тэтгэвэрт гарсан 4 алба хаагчийн хувийн хэрэг материалыг архивын үндсэн зааварт заасны дагуу цэгцэлж, архивын хадгаламжийн нэгж болгон хүлээлгэн өгөв.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны төлөвөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх 8 заалт бүхий салбар төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна. Мөн 2017 оныг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” жил болгон зарласан. Энэ ажлын хүрээнд аймгийн Боловсрол соёлын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд бичсэн танилцуулга, саналын тоо, шийдвэрлэлт: Цагдаагийн газраас 2017 онд Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад яам, агентлагт 1, аймгийн засаг даргад 7, аймгийн ГХУСАЗСЗ-д 11, сум, багийн засаг даргад 4, сумдын ГХУСАЗСЗ-д 11 нийт 45 ажлын санал бүхий 34 удаагийн танилцуулга хүргүүлж, 89,4 хувийг шийдвэрлүүлсэн байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн санал, танилцуулгыг үндэслэн харьяа Иргэдийн төлөөлөгчдийн хурал, ГХУСАЗСЗ-ийн тогтоол 5, Засаг даргын захирамж 2, хөтөлбөр 1, албан даалгавар 1, бусад 2 шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас санаачлан “Зам тээврийн осол хэргийг бууруулахад бүсийн аймгийн хамтын ажиллагаа” сэдэвт хамтарсан зөвлөгөөний үеэр гарсан зөвлөмжийг Монгол улсын Хууль зүйн яам, бүсийн аймгуудын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 41 дүгээр “Зөрчлийн улмаас түр саатуулагдсан мотоциклын эзэмшигчидэд нь буцаан олгох тухай” тогтоолыг гаргуулан “Мотоцикль” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд байгаа 200 гаруй мотоциклиудыг эздэд нь хүлээлгэн өгөх ажлыг амжилттай зохион байгуулсан.

“Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанаар архидалттай тэмцэх “Мэргэжлийн баг”-ийн төлөвлөгөө, төсөв зардлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, мөн 19 суманд энэ багийн байгуулах ажлыг эхлүүлэн нийт 22 “Аддиктологийн баг”-ийг байгуулсан. Аймгийн Засаг даргын А/561 дугаар захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн цагийн хуваарийг өөрчлөн батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Тус газрын хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, жижүүрийн офицер, хэрэг бүртгэгч, мөрдөгч нарт гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг шалгах аргачлал, 3 зааварчилга, 4 зөвлөмж боловсруулан хүргүүлж, биелэлтийг сар бүр тооцон ажилласны үр дүнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын ур чадвар, мэдлэг, хандлага дээшилсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2017 онд тус цагдаагийн газарт иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэр бүлийн гишүүнийг хэл амаар доромжилж, гэр бүлийн амгалан тайван байдал алдагдуулсан 296 дуудлага мэдээлэл хүлээн авсан байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 35, зөрчлийн шинжтэй 256 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 1.1 хувиар өссөн, зөрчил 53.2 хувиар өссөн байна.

Зөрчил гаргасан 256 иргэнийг Захиргааны хариуцлагын тухай хуулийн /хуучнаар/ 22 дугаар зүйлийн 22¹ зүйлээр 7-30 хоног шүүхээр 161 хүнийг баривчлуулж, 85 иргэнийг шийтгэлийн хуудсаар торгож, 7 гомдол мэдээллийг татгалзсан.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг үйлдэгдсэн нутаг дэвсгэрээр нь авч үзвэл Арвайхээр суманд 176 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос 2,2 хувиар өсч, Хархорин суманд-29, Тарагт-11, Богд-9, Сант-5, Нарийнтээл-3, Хайрхандулаан-2, Өлзийт-2, Зүүнбаян-Улаан-2, Гучин-Ус-1, Баруунбаян-Улаан-1, Бат-Өлзий-9, Уянга-5, Хужирт-7, Баян-Өндөр-2, Бүрд-3, Есөнзүйл-2 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гол, ой хээр”, “Зуслан”, “Хичээлийн шинэ жил”, “Цахим тоглоом”, “Илрүүлэлт-Оргодолт”, “Сэргээн шийдвэрлэлт”, “Сэргээн шийдвэрлэлт-2”, “Эвдрэл гэмтэл-техникийн зөрчил”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө, үзэмж”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт”, “Оюутан тээвэр” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Зам тээврийн ослын улмаас иргэд эрүүл мэнд, эд хөрөнгө, амь нас нь хохирох асуудал нэлээдгүй гарч байгаад анхаарал хандуулж, төв, орон нутгийн ялангуяа магистрал замуудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөлийг судалж, арилгуулах ажлыг зохион байгуулсаны үр дүнд 2017 онд зам тээврийн ослын 118 гомдол, мэдээлэл хүлээн авч үүнээс гэмт хэрэг 50 буюу урд оны мөн үетэй харьцуулахад 8-аар буюу 13.7 хувиар буурсан, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 68 буюу урьд оны мөн үеэс 444-өөр буюу 8 дахин буурсан байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн 2017 онд 17, урьд онд 22, харьцуулахад 5 буюу 22.7 хувиар буурсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 12.859 жолоочид бэлэн бус хэлбэрээр захиргааны арга хэмжээ ногдуулсан нь урд оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин, торгуулийн хэмжээ 1.7 дахин өссөн, эрх хассан шийтгэл нь 82.3 хувиар, баривчилсан шийтгэл 93.4 хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, хуваарийн дагуу “Эвдрэл гэмтэл-техникийн зөрчил”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө, үзэмж”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт”, “Оюутан тээвэр” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг хуваарийн дагуу зохион байгуулан ажилласан нь үр дүнтэй ажил болж, нас баралт буурсан, зөрчил илрүүлэлт өссөн сайн үзүүлэлттэй байна.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй болон түдгэлзүүлсэн хэргүүдийг нөхөн илрүүлэх, оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж баривчлах, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэргээн шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулж 104 хэрэг түдгэлзүүлсэн хэрэг сэргээгдэж 1 гэмт хэргийг шийдвэрлэж ажилласан. “Сэргээн шийдвэрлэлт-2” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж байна.

“Хичээлийн шинэ жил-замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөг боловсруулан батлуулж, сумдын хэлтэс, тасаг, хэсэг, сум, багийн хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан ба аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 30 сургууль, 53 цэцэрлэг, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн захиргаанд 2017-2018 оны хичээлийн жилтэй холбогдуулан оюутан сурагч, хүүхэд, багачуудыг зам тээврийн осол,

гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг, эх асран хамгаалагчдын үүрэг, хариуцлагын дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр оюутан, сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, архидан согтуурах, учирч болзошгүй эрсдэл, аюул, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 319 дугаартай ажил зохион байгуулах тухай албан мэдэгдлийг хүргүүлэн газар дээр мэдэгдлийн мөрөөр шалган зааварчлан хариуг бичгээр авч ажилласнаар сургууль, цэцэрлэгийн ойр орчимд хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй байна.

Аймгийн засаг даргын захирамжийн дагуу аймгийн Онцгой байдлын газар, мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Хөдөө аж ахуйн газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтран “Хяналт-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 1 сарын хугацаатай зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 11.351 хүнд 537.436.000 төгрөгийн бэлэн бус торгууль оногдуулсанаас аймгийн төрийн санд 310.881.225 төгрөгийн орлого төвлөрч 22.654.775 төгрөг төлөгдөөгүй байгаа учир орон нутгийн төсөвт төвлөрүүлэх авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдолын төлбөр орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлого хураалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр аймгийн засаг дарга 02 дугаар албан мэдэгдлийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын “а”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөр батлах тухай 15 дугаар тогтоолыг үндэслэн “Иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, зам тээврийн осол хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулахад төр, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсооё” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд олон нийтийн эргүүлээр ажиллах, байгууллага, аж ахуйн нэгжийн 2-оос доошгүй албан хаагдыг нэгдсэн зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөнөөс үүсэх хор, уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа нөлөөлөлийн ажлыг иргэд, олон нийтэд хүргэж ажилласанаар иргэдийн сэтгэлээ хандлага өөрчлөгдсөн үр дүнтэй ажил болж байна.

Энэхүү ажлын хүрээнд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 500 гаруй жолоочийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1-д зааснаар арга хэмжээ оногдуулсан хэдий ч нөгөөтэйгүүр тэднийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэнд, эд хөрөнгийг нь хамгаалж чадсан эерэг үр дүнгүүд харагдаж байна.

“Гол, ой хээр”, нэгдсэн арга хэмжээний хүрээнд байгалын үзэгслэнт газар нутаг ихтэй учраас дотоод гадаадын аялагч нар ихээр дамжин өнгөрч аяладаг цаг хугацаануудад иргэдэд тараах санамж, сэрэмжлүүлэгийг 3 төрлөөр нийт 3500 ширхэгээр хэвлэж, эрсдэл учирч болзошгүй 105 цэгт анхааруулга самбар байрлуулан ажилласанаар иргэдийн сонор сэрэмж дээшилсэн үр дүнтэй ажил болсон.

Арга хэмжээний хугацаанд 19 сумын хэмжээнд урсаж байгаа гол мөрөн 8, нуур цөөрөм 18, булаг рашаан 5, худаг ус 45 нийт 76 ус мөрний судалгааг гаргаж эргүүлийн чилэлд авч өдөрт 4-6 цагийн үүрэг гүйцэтгэж ажиллав. Иргэдийг усанд осолдож болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гол, нуур цөөрөм, худагаас 500 метрийн зайнд “Анхааруулга” самбарыг байрлуулан ажиллаж, морин болон мотоциклиор эргүүлийн үүргийг гүйцэтгэн хяналт тавьж ажилласанаар тухайн цэгүүдэд хүн, мал, амьтан осолдсон гэмт хэрэг, зөрчил гараагүй болно.

Аймгийн Онцгой байдлын урьдчилан сэргийлэх албатай хамтран аймаг, сумын төвөөс алслагдсан томоохон гол буюу “Орхон”, “Таац”, “Онги” голын ай сав газраар нутаглаж байгаа иргэд, малчидад үер усны аюулгүйлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэж ажилласнаар томоохон голын ойр орчимд амьдарч байгаа иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн үр дүнд хүрсэн.

Аймгийн төвийн баруун пост, Хархорин, Хужирт, Бат-Өлзий сумдын сумаас гарах хаалга, постуудад 2-3 алба хаагчдыг ажиллуулж “Гол усны аюулаас урьдчилан сэргийлье”, “Усанд живэхээс урьдчилан сэргийлж, заавал анхаарах асуудлууд”, “Гол усанд осолдохоос болгоомжил”, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлье”, “Түймэр юунаас болж гардаг вэ?” гэх мэт фото зурган сэрэмжлүүлэгийг байрлуулж, дотоод гадаадын аялагч давхардсан тоогоор 2500 гаруй иргэдэд тараан ажилласан. Арга хэмжээний хүрээнд иргэдийг болзошгүй осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргэх ажлын хүрээнд аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газартай хамтран орон нутгийн 4 телевиз, FM радио 1, байгууллагын вэб сайт, пэйж хуудсаар болон цахим мэдээллийн хэрэгслүүдээр сэрэмжлүүлэгийг хүргэсэн.

Хиймэл нуур, цөөрөм ашиглаж буй амралт, аялал жуучлалын бааз, аж ахуйн нэгжүүдийн харуул, хамгаалалтыг сайжруулах, аюулгүй байдлаа хангаж ажиллах чиглэлээр 35 албан мэдэгдлийг хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн албан ажил үүргээ гүйцэтгэхэд нь аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, хэрэгжилтэнд нь биечлэн хяналт тавьж ажилласан.

2016 онд бүртгэгдсэн эрүү болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулгыг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, санал гаргасанаар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2017 оныг “Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” жил болгон зарлуулсан.

Арвайхээр сумын ИТХ-ын 26 дугаар тогтоолоор “Хөршийн холбоо” байгуулах журмыг хэрэгжүүлж, энэ ажлын хүрээнд “Хөршийн холбоо”-ны гишүүдтэй уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж “Итгэлцэлийн гэрээ” байгуулан хамтран ажиллаж байна. Дээрх иргэдийг баг, хороон дээр ажиллуулсанаар гудамж, талбайд үйлдэгдэгдэх гэмт хэргийн гаралт энэ оны байдлаар 93.2 хувиар буурсан.

Монголын Хуульчдын холбооны Өвөрхангай аймаг дахь салбар байгуулагдсаны 1 жилийн ойг тохиолдуулан “Хуулийн байгууллагуудын нэгдсэн нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр “Аюуш” баатрын талбайд зохион байгуулагдаж, арга хэмжээнд аймгийн Хууль эрх зүйн хэлтэс, Шүүх, Прокурор газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба, Өмгөөлөгчдийн зөвлөл, Нотариатын салбар, Хүний эрхийн салбар зөвлөл зэрэг хууль хяналтын байгууллагын болон Архивын тасаг, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, иргэд олон нийт өргөнөөр оролцов. Өдөрлөгт оролцогч байгууллагууд өөрсдийн онцлог чиг үүргийн хүрээнд хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч, байгууллагынхаа ажил, үйлчилгээг сурталчлах, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг нь хүлээн авч, шаардлагатай тохиолдолд газар дээр нь шийдвэрлэх чиглэлээр ажиллалаа. Энэхүү арга хэмжээнд Цагдаагийн газраас байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, цагдаагийн мэргэжлийн албадын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх

зорилгоор “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор хамтран зохион байгуулсан.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран орон нутгийн Арвайхээр телевизтэй хамтран бага насны хүүхдүүдийг учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд ба эрсдэл” цуврал нэвтрүүлэгийн 3-н дугаар бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малын хулгайн гэмт хэргээс хамтдаа урьдчилан сэргийлье” шторкыг бэлтгэн иргэдэд хүргэсэн.


2. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

Тус цагдаагийн газар нь 2017 онд 1956 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 913 буюу 46.6 хувийг эзлэж байна. Үүнээс 557 буюу 38.9 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 349 буюу 61.7 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, үлдэгдэл 7 гомдол, мэдээлэлтэй байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 99.2 хувийг шийдвэрлэсэн.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1043 буюу 53.4 хувийг эзэлж байгаагаас 498 буюу 52.3 хувийг ердийн зөрчил, 223 буюу 21.3 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 190 буюу 18.2 хувийг баривчлах, 11 буюу 1.0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл, 105 буюу 10.1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 12 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн, үлдэгдэл 4 зөрчлийн шийнжтэй гомдол, мэдээлэлтэй байна. Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 99.6 хувийг шийдвэрлэсэн байна.



Хүлээн авсан гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 609 буюу 66.7 хувийг 5 хоногт, 297 буюу 32.5 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 746 буюу 71.5 хувийг 3 хоногт, 293 буюу 28.0 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.



Бүртгэгдсэн гэмт хэрэг

Өвөрхангай аймгийн хэмжээнд 492 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 16 хэргээр буюу 3.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Арвайхээр суманд 174 хэрэг бүртгэгдсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад 25 хэргээр буюу 12.5 хувиар буурчээ.

Сумдад бүртгэгдсэн хэргийн гаралтыг судлаж үзэхэд Бүрд, Баянгол, Бат-өлзий, Баруунбаян-улаан, Гучин-ус, Есөнзүйл, Богд, Нарийнтээл, Сант, Хужирт сумдад урьд оны мөн үеэс 16.6 хувиас 1.4 дахин хэрэг өссөн үзүүлэлттэй байна.

Бүрд, Баянгол, Бат-өлзий, Гучин-ус, Есөнзүйл, Тарагт, ББУлаан сумдад иргэдийн өмчийн хулгай болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг өссөн.

Согтуугаар үйлдэгдсэн хэрэг нь Арвайхээр суманд 38, Хархорин, Тарагт сумдад 6, Нарийнтээл суманд 5 бүртгэгдэж










хамгийн их байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Уянга сумдад тус бүр 4, Богд, Хайрхандулаан сумдад 3, Баян-өндөр, Баянгол, Гучин-Ус, Сант, Хужирт, Есөнзүйл сумдад тус бүр 2, Баруунбаян-Улаан, Өлзийт, Төгрөг сумдад тус бүр 1 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн нь иргэдийн дунд архидан согтуурах явдал их байгааг харуулж байна. Энэ төрлийн хэргийн 21.7 хувь нь согтуугаар үйлдэгджээ.


Өвөрхангай аймагт сард дундажаар 26.4 гэмт хэрэг үйлдэгдэж байна. Нийт бүртгэгдсэн хэргийн 318 буюу 64.6 хувь нь хөдөө сумдад, 174 буюу 35.3 хувь нь аймгийн төвд үйлдэгдсэн.


Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн төрлөөр/

	2016 он	2017 он	Гэмт хэргийн өсөлт, бууралт	
			тоо	хувь
	6	<u>Хүнийг алах</u> 8	+ 2	33.3%
	12	<u>Танхай</u> 4	-8	-3 дахин
	5	<u>Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх</u> 7	+2	40.0%
<u>Хүрээлэн буй орчны эсрэг</u>				


	6	19	+13	3.1 дахин
	204	Хулгайлах 212	+8	3.9%
	159	<u>Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг</u> 139	-20	12.5%
	5	<u>Залилах</u> 7	+2	40.0%
	51	<u>Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг</u> 33	-18	-35.2%
	58	<u>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг</u> 45	-13	-22.4%
	5	<u>Хүчиндэх</u> 6	+1	+20.0%
	25	<u>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг</u> 31	+6	+24.0%
	30	<u>Бүлэглэн үйлдэгдсэн хэрэг</u> 43	+13	+43.3

Гэмт хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлт





Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцээр харуулбал



2017 оны 07 дугаар сарын 01-нээс Шинээр хэрэгжиж буй “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-уудын дагуу Хэрэг бүртгэх тасаг нь 2017 онд харъяаллын нийт 155 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авч, үүнээс 46 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 13 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, 22 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 74 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж 74 хүнийг 7.400.000 төгрөгөөр торгож шийдвэрлэв. Үлдэгдэл гомдол, мэдээлэл байхгүй байна. Зөрчлийн 46 хэрэг нээн зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 14 хоногт нь шалган, 45 хэргийг шийтгэл оногдуулахаар прокурорт шилжүүлэн, шүүхээс 48 хүнд баривчлах шийтгэлийг оногдуулсан байна. Саатуулсан хүн 1 байна. Нийт иргэд байгууллагад 1.694.000 төгрөгний хохирол учирсныг 100% гэм буруутай этгээдүүдээр нөхөн төлүүлж барагдуулсан.

Мөрдөн байцаалтын шатанд 2017 онд иргэд, байгууллага, албан тушаалтнаас 394 гомдол мэдээлэл хүлээн авч 387 гомдол мэдээллийг шийдвэрлэсэн үүнээс 227 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж 154 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт хүргүүлж 6 гомдол мэдээллийг харъяаллын дагуу бусад газарт шилжүүлж 7 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Нийт хүлээн авсан гомдол мэдээллийн 98.2 хувийг шийдвэрлэсэн. Гомдол мэдээллийн шийдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өссөн. Нийт 401

холбогдогчтой 437 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 259 холбогдогчтой 204 эрүүгийн хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх болон шүүхэд шилжүүлэх саналтай, 20 холбогдогчтой 58 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж 35 холбогдогчтой 50 хэргийг нэгтгэн нийт 314 холбогдогчтой 312 эрүүгийн хэргийг шийдвэрлэж мөрдсөн хэргийн 72 хувийг шийдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Нэг мөрдөгч улиралд 9.9 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж 7 эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн, жилд нэг мөрдөгч 39.7 хэрэг шалгаж 28.3 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн. Нийт шийдвэрлэсэн 312 эрүүгийн хэргээс 303 хэргийг хуулийн анхны хугацаанд букуу 97 хувийг шийдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Шийдвэрлэсэн хэргээс шүүхээс 7, прокуророос 21 нийт 28 хэрэг буцсан нь нийт шийдсэн хэргийн 8.9 хувийг эзэлж байгаа ба өмнө оноос гологдол 2.4 хувиар буурсан байна. Өмнөх онд шүүхээс 17, прокуророос 24 эрүүгийн хэрэг буцаж байсан.

Гэмт хэргийн улмаас 706.586.640 төгрөгийн хохирол учирснаас 649.305.462 төгрөгний хохирол нөхөн төлүүлж 91.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн, 338.837.000 төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн нь 164.654.000 төгрөгөөр өмнөх оноос өссөн.

Шинээр батлагдсан Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн дагуу түдгэлзүүлсэн 109 эрүүгийн хэргийг сэргээн Эрүүгийн цагдаагийн тасагт хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийлгүүлэхээр шилжүүлсэн. Урьд түдгэлзээтэй байсан Мишигдоржийн Жумдаанд холбогдох Эрүүгийн хуулийн 181.3 дах хэсэгт заасан эрүүгийн 20610717 тоот хэрэг, Ганболдын Даваажаргалд холбогдох Эрүүгийн хуулийн 17.1.1, 17.3.1 дэх хэсэгт заасан эрүүгийн 201715000123 дугаартай хэргүүдийн мөрдөн байцаалтын ажиллагааг сэргээсэн, түдгэлзүүлсэн хэрэг байхгүй.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 9 сэжигтэн, яллагдагчид авсан одоо цагдан хоригдсон яллагдагч байхгүй.

Яллах дүгнэлт үйлдүүлэх, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн эрүүгийн 204 хэрэгт мөрдөгчийн мэдэгдэл бичиж мэдэгдлийн 184 хариу авсан нь 91 хувийг эзэлж байна. Бусад газраас ирүүлсэн 62 мөрдөгчийн даалгаврыг гүйцэтгэн хариуг хүргүүлж бусад газарт мөрдөн байцаалтын ажиллагаа гүйцэтгүүлэхээр 15 мөрдөгчийн даалгавар бичсэн. Аймгийн хэмжээнд мөрдөн байцаалтын хүнд 35, эзэнгүй болон хөнгөн хэрэгт 98 нийт 133 эрүүгийн хэрэгт тасаг, хэсгийн дарга даалгавар, зааварчилга бичиж үр дүнг тооцсон нь нийт шалгасан хэргийн 31 хувийг эзэлж байна. Одоо ажиллагаанд 71 хүнтэй 59 үйлдэлтэй 58 эрүүгийн хэрэг шалгагдаж байна. Шүүх, прокуророос буцсан хугацаа сунгасан 3 эрүүгийн хэрэг байна.

Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нар 636 мэдээ, мэдээлэл авч баримтжуулан шалгаж 248 холбогдогчтой, 325865,0 мянган төгрөгний хохиролтой, 128 материалаар 276 хэрэг үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шилжүүлэн ажилласан байна. Илрүүлсэн 276 хэрэг үйлдлээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 15 хэргийг нөхөн илрүүлж ажилласан байна. Гүйцэтгэх ажил зохиолгохоор хэрэг бүртгэх мөрдөн байцаах албанаас 38 даалгавар хүлээн авч хариуг хугацаанд нь өгч, бусад албадаас гэмт хэргийн талаар 97 илтгэх хуудсыг хүлээн авч шалгаж шийдвэрлэж ажиллав.

Мөнгө угаах авлига, албан тушаалын болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр аймгийн хэмжээнд олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн эх үүсвэр ихтэй, аж ахуй нэгж, байгууллага болон гадаадын шашны байгууллагын санхүүгийн эх үүсвэрт гүйцэтгэх ажлын шугамаар хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд одоогоор сэжиг бүхий зүйл илрээгүй байна.

2017 оны 09 дүгээр сард аймгийн БОЭТ-ийн Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний их эмч Б.Алтантөгстэй хамтран ажиллаж байнгын болон түр хугацааны хяналтанд байдаг 45 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргаж тэдний хэрэглээнд нь хяналт тавин

ажиллаж байна.Аймгийн хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон эмийн чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага нийт 43 байна.

Эмийн үйлдвэр байхгүй Эмийн сан 39, Эм ханган нийлүүлэх байгууллага 4, Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эмбио бэлдмэлийн улсын байцаагч О.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн газрын эмийн бодлогоын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, эмийн төлөвлөлт, хангалт хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэтуяа, Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан, дэд хурандаа Ш.Энхболд нартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийтийн эмийн сангуудын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавин зарцуулалтын тайланг авч хяналт тавин ажиллаж байна.

Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин хууль бусаар мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэдэг, энэ төрлийн гэмт хэрэгт Монгол бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж “Зөв сонголт, Эрүүл амьдрал” нэртэй сэрэмжлүүлэг материалыг сургалтанд хамрагдсан оюутан, сурагчдад тарааж ажиллалаа.

Хар тамхи, Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын төрөл нэршил, сэжигтэй этгээд байр байгууламж, тээврийн хэрэгсэлд үзлэг нэгжлэг хийхэд анхаарах асуудал сэдвээр хэсгийн төлөөлөгч нарын 1, 3, 4 дүгээр улирлын сургалт, цугларалтаар сургалт зохион байгуулж Multi-Drug /Heroin-MET-COC-AMP-THC-KET/ буюу шээсээр мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тестийг хэрхэн ашиглах талаар сургалт орж ажиллав.

Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг Соёмбо, Арвайхээр, GM, Хас телевизүүд, Ноён уул, 102.6 FM, радио, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын нээлтэй Facebook page хуудсан дээр Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нийгэмд учруулах хор аюулыг олон нийтэд таниулах мэдээллийг иргэдэд хүргэж, урьдчилсан сэргийлж ажиллаж байна.

2017 онд Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай 18.5 дугаар зүйл, 20.7 дугаар зүйл, 20.8 дугаар зүйл, 20.9 дүгээр зүйл, 20.10 дугаар зүйлд заасан хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг тус цагдаагийн газарт бүртгэгдээгүй байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт ял шийтгэгдэн суллагдсан, энэ төрийн мансууруулах үйлчилгээтэй бодист донтсон, хамаарал бүхий этгээдүүд байхгүй.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг мансууруулах үйлчилгээтэй ургамлын түүхий эдийг хэрэглэх бусдад худалдах зорилгоор хууль бусаар ургуулж тарьж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн талаар мэдээ мэдээлэл авагдаагүй болно.

3. Эрэн сурвалжлах ажлын талаар:

Гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдсон этгээдүүдийг Асап сангаас тогтмол шүүн ажиллахын зэрэгцээ эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэх бүрт Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах, Нийтийн хэв журам хамгаалах, Замын цагдаагийн тасгийн дарга нараас Асап сангийн мэдээлэл тогтмол тулгалт хийж эрэн сурвалжлалтыг зогсоож байна.

Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх алба, Замын цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах алба болон бусад цагдаагийн газар, хэлтсээс ирсэн хугацаатай албан бичиг, үүрэг, ажлын чиглэлийн хариуг хугацаанд нь гарган өгч ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/178 дугаартай тушаалаар батлагдсан “Илрүүлэлт-Оргодол”, Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Д.Наранбаатарын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

баталсан “Шийдвэрлэлт-2017” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд зохион явуулах ажлын төлөвлөгөө Цагдаагийн газрын даргаар батлуулан алба хаагч нарт хүргүүлэн зохион байгуулав.

Эрэн сурвалжлах “Асап” санд оруулсан мэдээллийг хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байсан хэрэг бүртгэлтийн хэргийн алдагдсан эд зүйл, оргодол этгээдүүдтэй тулгалт хийж эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдаж байгаад оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйл, мал амьтаны мэдээллийг нэгдсэн арга хэмжээ эхлэхээс өмнө санд шивж оруулах, шаардлагатай мэдээллийг засварлах талаар алба хаагч нарт мэдэгдэн мэдээллүүдийг засварлан оруулсан.

Мөн Гэмт хэрэгтэй тэмцэх албаны даргаас 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 5/6414 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу тус газраас эрэн сурвалжлах “Асап” санд 5425 маягтаар бүртгэгдсэн 162 мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 229-ын 229.13 дахь хэсэгт заасны дагуу эрэн сурвалжлалтыг зогсоов.

Эрэн сурвалжлах “Асап” санд мэдээлэл шивж оруулах эрх бүхий алба хаагч нараас тухай онд дараах мэдээллийг шивж оруулсан байна.

Алга болсон хүн эрэн сурвалжлах жагсаалтанд 17 мэдээлэл бүртгэгдэж 16 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 94.1 хувьтай, шүүхээс даалгасан хүн эрэн сурвалжлах жагсаалтанд 33 мэдээлэл бүртгэгдэж 16 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 48.4 хувьтай, оргодол эрэн сурвалжлах жагсаалтанд 23 мэдээлэл бүртгэгдэж 15 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 65.2 хувьтай, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд 18 мэдээлэл бүртгэгдэж 16 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 88.8 хувьтай, тээврийн хэрэгсэл эрэн сурвалжлах жагсаалтанд 13 мэдээлэл бүртгэгдэж 3 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 23 хувьтай, мал амьтан эрэн сурвалжлах жагсаалтанд 49 мэдээлэл бүртгэгдэж 2 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 4 хувьтай, эд зүйл эрэн сурвалжлах жагсаалтанд 81 мэдээлэл бүртгэгдэж 5 эрэн сурвалжлалтыг зогсоож гүйцэтгэл 6.1 хувьтай байна.

Эрэн сурвалжлах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах орон тооны бүс зөвлөлөөр улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа мэдээллүүдтэй алба хаагч нар 50 доошгүй хувьтай танилцсан байх шийдвэр гарган үр дүнг тооцож байгаа бөгөөд Эрэн сурвалжлах Асап сангаар эрэн сурвалжлагдаж байгаа мэдээллүүдтэй тус газрын алба хаагч нараас 95.787 /**ерэн таван мянга долоон зуун наян долоо**/ хандалт хийв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын баталсан 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаар тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр Өвөрхангай аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн захирамж, шийдвэрээр эрэн сурвалжлагдаж байсан 33 этгээдийн эрэн сурвалжлах материалд тус цагдаагийн газрын шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн ахлах байцаагч, бусад холбогдох албан тушаалтан нар ажиллагааны материалын бүрдүүлэлт, сангийн зөрчилд тулгалт хийж эрэн сурвалжлах ажиллагааг хариуцан явуулж байгаа алба хаагч бүрт үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлэн биелэлт үр дүнг нь тооцон ажилласаны үр дүнд 16 этгээдийг олж тогтоосон.

“Шийдвэрлэлт-2017” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Аймгийн хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа Эрэн сурвалжлах “Асап” сангийн алга болсон хүн эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн 4, шүүхээс даалгасан хүн эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн 10, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн 3, оргон зайлсан сэжигтэн, яллагдагч эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн 2 нийт 19 этгээдийн мэдээллийг тус цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд зарлан мэдээлж тухайн этгээдүүдийг олж тогтоох чиглэлээр мэдээлэл цуглуулах үүргийг өгч биелэлтийг тооцон ажиллаа.

Мөн “Асап” санд оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, алга болсон хүн, шүүхээс даалгасан хүний мэдээллийг давхардуулсан, буруу мэдээлэл оруулсан эсэхэд тулгалт хийхэд ямар нэгэн зөрчил илрээгүй.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Эрэн сурвалжлах “Асап” сангийн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн Лавсанжанцангийн Эрдэнэбаяр /540004217000278, 541204217000014/, Батсүхын Оюун-Ундраа /540004217000251, 541204217000011/, Сономжаагийн Доржсүрэн /540004217000234, 541204217000009/, шүүхээс даалгасан хүн эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн Болдын Амгаланбаатар 540004217000265, /541104217000012/, Ойдовын Мөнхбат /540004217000203, 541104217000003/, Нэргүйн Лодойдамба /540004216000207, 541104216000031/, Бямбадоржийн Энхбат /540004217000269, 541104217000014/, Бадамчулууны Мөнхсайхан /540004217000279, 541104217000016/, Өлзийбаатарын Зэвгэ /540004217000282, 541104217000019/, Хандын Эрдэнэгэрэл /540004217000283, 541104217000018/, Үржинсүрэнгийн Тогооцэрэн /540004217000281, 541104217000017/, Сосорын Ренням /540004217000205, 541104217000005/, Бямба Балжинням /540004217000204, 541104217000004/ нарын 13 этгээдийг олж тогтоон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 229/-д заасныг баримтлан эрэн сурвалжлалтыг зогсоосон талаар Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн хоногийн мэдээнд тухай бүр өгч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/178 дугаартай тушаалаар батлагдсан “Илрүүлэлт-Оргодол нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус газраас дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээг зохион явуулах ажлын төлөвлөгөөг гарган батлуулж Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Хужирт сум дахь цагдаагийн тасаг, Уянга, Бат-Өлзий сум дахь Цагдаагийн хэсэг, сум хариуцсан хэсгийн төлөөлөгч, бусад холбогдох тасаг, алба хаагч нарт хүргүүлэн биелэлт үр дүнг нь тооцон ажиллаа.

Нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, Эрэн сурвалжлах ажлын журмыг хэрэгжүүлэх, “Асап” сангийн ашиглалтыг сайжруулах зорилгоор 2017 оны 09 дүгээр сарын 15, арга хэмжээний явц, үр дүнд сайжруулах, ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрүүдэд хэлтэс, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч нар хугацаатай үүргийг хүргүүлсэн биелэлтийг нь тухай бүр тооцон. Эрэн сурвалжлах “Асап” санд оруулсан мэдээллийг хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байсан хэрэг бүртгэлтийн хэргийн алдагдсан эд зүйл, оргодол этгээдүүдтэй тулгалт хийж эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдаж байгаад оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйл, мал амьтаны мэдээллийг нэгдсэн арга хэмжээ эхлэхээс өмнө санд шивж оруулах, шаардлагатай мэдээллийг засварлах талаар алба хаагч нарт мэдэгдэн мэдээллүүдийг засварлан оруулсан.

Өвөрхангай, Архангай, Булган аймгуудын нутгаас нийт 93 удаагийн үйлдэлээр орон байр, мал, тээврийн хэрэгсэлийн хулгай, дээрмийн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч Ганбаатарын Түдэв, Дамдинсүрэнгийн Сугар-Адьяа, Гончигсүрэнгийн Хархүү, Цоодолын Баттулга, Михлайн Ганболд, Төмөрын Батбаатар, Бадамдарийн Мөнхбаяр, Зоригтын Норовренчин, Цоодолын Отгонбаяр, Дамдинсүрэнгийн Шийлэгбат нарт холбогдох эрүүгийн 201515000278 тоот хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлэн шийдвэрлэсэн.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө Эрэн сурвалжлах “Асап” сангийн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд 5, оргодол эрэн сурвалжлах жагсаалтанд 8 этгээд эрэн сурвалжлагдаж байсан бөгөөд алба хаагч нарыг Улаанбаатар хот Өмнөговь, Архангай,

Төв, Булган аймгуудад томилолтоор ажиллуулж гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн Михлайн Ганболдыг Архангай аймгийн Цэцэрлэг сумаас, Доржийн Амгаланбаатар, Тунгалагын Ариунболд нарыг Улаанбаатар хотоос, Бямбын Адьяанямыг Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас, оргодол эрэн сурвалжлах жагсаалтанд бүртгэгдсэн Цоодолын Баттулгыг Булган аймгийн Рашаант сумаас, Дамдинсүрэнгийн Сугар-Адьяаг Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас, Ганбаатарын Түдэв, Риймэдийн Бүтэнсайн нарыг Улаанбаатар хотоос, Бадамдарийн Мөнхбаярыг Өмнөговь аймгийн нутгаас, Ойдовнямын Нямбаатарыг Өвөрхангай аймгийн Хархорин сумаас тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг “Асап” санд зогсоон Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвд тухай бүр мэдээг өгч ажилласан бөгөөд эрэн сурвалжлах ажиллагааны явц 83.3 хувьтай байна.

Эрэн сурвалжлах Асап санд 5412 маягтаар /оргодол эрэн сурвалжлах, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд/ 32 этгээдийг олж тогтоон холбогдох албадад хүлээлгэн өгч шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо иргэн Б.Бат-Очирын авто машины салхины шилийг хагалж хэргийн газраас оргон зайлсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан Алтанцэцэгийн Ганбат гэгчийг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Богд сумын 4 дүгээр багийн нутгаас хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч А.Даваадэмбэрэл олж тогтоон холбогдох албадад хүлээлгэн өгч ажиллав.

2. 2015 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Арвайхээр сумын 2 багт 22-26 тоотод оршин суух 14 настай Т.Нармандах гэгчийг хүчиндэж хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201515000274 тоот хэргийн оргодол этгээд Нямсүрэнгийн Сэмжиан гэгчийг 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Баянхонгор аймгийн Өлзийт сумаас Баруунбаян-Улаан сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ж.Отгонбаатар

3. 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Арвайхээр сумын 9 дүгээр багийн нутгаас эд зүйл хулгайлан эрүүгийн 20161500033 тоот хэрэгт сэжигтнээр тооцогдон шалгагдаж байгаа оргон зайлсан Батмөнх овогтой Сүхбаатар гэгчийг эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Азжаргал 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Баянгол сумаас

4. 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Бат-Өлзий сумын төвд иргэн Т.Өсөхбаяр гэгчийг тээврийн хэрэгсэл жолоодон яваад дайрч биед нь хүндэвтэр зэргийн гэмтэл учруул эрүүгийн 201615010150 тоот хэрэг Дашдовын Бат-Эрдэнэ гэх хуурамч нэрээр яллагдагчаар татагдан шалгагдаж байгаад оргон зайлсан Дашдондовын Бат-Цоож гэгчийг Бат-Өлзий сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ц.Самдантүвдэн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотоос,

5. 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Зүүбаян-Улаан сумын 3 багийн Угалзын ам гэх газар оршин суух иргэн З.Адьяасүрэнгийн 1 тооны морийг бусадтай бүлэглэн хулгайлж эрүүгийн 201715000048 тоот хэрэгт сэжигтнээр тооцогдон шалгагдаж байгаад оргон зайлсан Батбаярын Мөнхбаяр гэгчийг 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдөр мөрдөгч, цагдаагийн дэслэгч Ч.Цогтбаяр Улаанбаатар хотоос,

6. Эрүүгийн хэрэгт тус цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт яллагдагчаар татагдан шалгагдаж байгаад оргон зайлсан Лхагвасүрэнгийн Энхболд гэгчийг мөрдөн байцаах тасгийн алба хаагч нар 2017 оны 09 сарын 13-ны өдөр Арвайхээр сумын нутгаас,

7. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Бадамдарийн Мөнхбаярыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч П.Буянбаяр Дундговь аймгийн нутгаас,

8. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор

эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Ганбаатарын Түдэвийг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч П.Буянбаяр Зүүнбаян-Улаан сумын нутгаас,

9. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Риймэдийн Бүтэнсайныг цагдаагийн ахлах дэслэгч Э.Өлзийжаргал Улаанбаатар хотын нутгаас,

10. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Дамдинсүрэнгийн Сугар-Адьяаг цагдаагийн хошууч Б.Мөнх-Эрдэнэ Арвайхээр сумын нутгаас,

11. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Цоодолын Баттулга гэгчийг цагдаагийн ахлах дэслэгч Э.Бямбацэрэн Архангай аймгийн нутгаас,

12. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 2017 оны 38 дугаартай тогтоолоор эрүүгийн 201515000278 тоот хэрэгт яллагдагчаар эрэн сурвалжлагдаж байсан Ойдовнямын Нямдоржийг цагдаагийн ахлах дэслэгч Э.Бямбацэрэн Хархорин сумын нутгаас,

13. 2017 оны 03-р сарын 31-ний өдөр Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны гүүрэн дээр зам тээврийн осол гарган хэргийн газраас зугтсан Алтангэрэл овогтой Отгонтулга нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа оргон зайлсаныг Хархорин сумын цагдаагийн хэлтсийн алба хаагч нар Улаанбаатар хотоос,

14. Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 2 дугаар баг 14-01 тоотод хохирогч Ц.Гантулгын толгойн тус газар нь архины шилээр цохиж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэмт хэргийг үйлдээд прокурорын шатнаас оргон зайлсан Самдандамбын Алтанцэцэгийг цагдаагийн ахлах дэслэгч Ч.Амартүвшин Уянга сумын нутгаас,

15. 2017 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр Тарагт сумын иргэн А.Юндэн гэгчийн Мустанг-5 маркын мотоциклийг хулгайлан хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201715000017 тоот хэргийн оргодол этгээд Лхагвадоржийн Нямжаргал гэгчийг эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Азжаргал 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Богд сумаас,

16. 2017 оны 12 дугаар сарын 13-14 шилжих шөнө Өвөрхангай аймгийн Хужирт сум 1 дүгээр багийн нутаг Холбоогийн ар гэх газраас иргэн Д.Туяагийн 2 тооны морийг хулгайлсан, 2016 оны 12 дугаар сарын 19-20 нд шилжих шөнө Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 3 дугаар багийн нутаг Цохиот гэх газраас иргэн Ц.Ганболдын хурдан удмын хээр зүсмийн буурал морийг хулгайлсан гэх эрүүгийн тоот хэргийн оргодол этгээд Сономжаа овогтой Доржсүрэнг Хужирт сумын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч З.Мягмарсүрэн 2017.05.19 өдөр Архангай аймгийн нутгаас,

17. 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Арвайхээр сумын 9 баг 5-06 тоотод оршин суух иргэн Ц.Даваасүрэн гэгчийн гэрээс эд зүйл хулгайлан хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201615000354 тоот хэргийн оргодол этгээд Дуламжаргалын Балжинням гэгчийг 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Азжаргал Улаанбаатар хотоос,

18. 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Арвайхээр сумын 3 дугаар баг 12-01 тоотод оршин суух иргэн Г.Дашзэвэг гэгчийг гэгчийг зодож биед нь хүндэвтэр гэмтэл учруулан хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201715000058 тоот хэргийн оргодол этгээд Дашзэвэгийн Гансүх гэгчийг 2017 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Азжаргал Улаанбаатар хотоос,

- 19.2017.02.09-ны өдөр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р багийн БОЭТ дотроос Богд сумын иргэн Б.Түмэн-Өлзий гэгчийн 780.000 төгрөгийг хулгайлан хэргийн газраас оргон зайлсан Батсүхын Оюун-Ундраа гэгчийг Улаанбаатар хотын нутгаас хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмарсүрэн,
- 20.2017 оны 04 сарын 17-ны өдөр Өвөрхангай аймгийн Өлзийт сум 1 баг Баянхошуу гэх газар иргэн Ц.Даваасүрэнг хамтран амьдрагч Л.Эрдэнэбаяр нь зодож улмаар гэрээс нь 2 ширхэг гар утас, 1 ширхэг хөөрөг, 520000 төгрөг бэлнээр хулгайлан оргон зайсаныг Өлзийт сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ц.Хад-Оргодол,
- 21.2017 оны 03-р сарын 31-ний өдөр Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны гүүрэн дээр зам тээврийн осол гарган хэргийн газраас зугтсан Алтангэрэл овогтой Отгонтулга гэгчийг Хархорин сумын цагдаагийн хэлтсийн алба хаагч нар,
- 22.Өвөрхангай аймгийн Богд сумын 5 дугаар багийн иргэн О.Мэндaмaр гэгчийн ноолуур, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын 2 дугаар багийн иргэн Х.Отгонхүү зэргийн мотоциклийг хулгайлан хэргийн газраас оргон зайлсан Ганболдын Даваажаргалыг цагдаагийн ахлах дэслэгч А.Даваадэмбэрэл Өмнөговь аймгийн нутгаас,
- 23.2017 оны 06 сарын 16-ны шөнө арвайхээр сумын 5-р баг 40-н айлын орон сууцнаас иргэн Б.Батболдын хаан банкны виза картыг хулгайлан авч 900.000 төгрөгийн бэлэн мөнгөний АТМ-аас уншуулж аваад оргон зайлсан Тунгалагын Ариунболд гэгчийг цагдаагийн ахлах дэслэгч М.Доржсүрэн Улаанбаатар хотоос,
- 24.Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 5 дугаар багт оршин суух иргэн Б.Алтанчимэгийн гэрт хулгай орж эд зүйл алдагдсан гэх эрүүгийн 172700024 тоот хэрэгт гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан Михлайн Ганболд гэгчийг цагдаагийн ахлагч Ц.Батзориг Архангай аймгийн нутгаас,
- 25.Өвөрхангай аймгийн уянга сумын 7-р баг Бөөрөлжүүт гэх газарт Сэнгэ-Адир ХХК-н захирал нь АУМ алт ХХК-тай нөхөн сэргээлтийн туслан гүйцэтгэх гэрээ хийчихээд лицензийн мөнгө болох 16 сая төгрөгийг өгөлгүй зугтаасан гэх хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Доржийн Амгаланбаатарыг цагдаагийн ахлах дэслэгч Б.Энх-Орлон Улаанбаатар хотын нутгаас,
- 26.Эхнэр З.Оюунсүрэнг удаа дараа зодож биед нь гэмтэл учруулсан гэх 172600010 тоот хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Бямбын Адьяанямыг цагдаагийн ахлах дэслэгч М.Доржсүрэн Арвайхээр сумын нутгаас,
- 27.Арвайхээр сумын 9-р баг 10-6 тоотод оршин суух иргэн Ш.Цэндсүрэнгийн байшинд хууль бусаар нэвтэрч эд зүйл хулгайлсан гэх хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Оюуны Нямтогтох гэгчийг цагдаагийн ахмад Д.Бат-Оргил Арвайхээр сумын нутгаас,
- 28.2017 оны 10 сарын 08-ны өдөр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 11-р багийн иргэн О.Гантөмөрөөс удахгүй мөнгийг нь өгнө гэж 5 тооны хонь, бэлэн 65000 төгрөгийг залилж оргон зайлсан Намжаагын Долгормааг цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмарсүрэн Улаанбаатар хотоос,
- 29.2016 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Хархорин сумын Орхон гол гэх газар бусдыг зодож биед хөнгөн зэргийн гэмтэл учруулан хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201615010132 тоот хэргийн оргодол этгээд Цэрэндагва овогтой Ганбаатар гэгчийг 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотоос эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч Ч.Дэлгэрнасан,
- 30.2016 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Бат-Өлзий сумын 5 баг Доод өргөн чөлөө гэх газар оршин суух иргэн Б.Болд-Эрдэнэ гэх айлаас эд зүйл хулгайлан хэргийн газраас оргон зайлсан эрүүгийн 201615010165 тоот хэргийн оргодол этгээд Чимэджагдагын Жамъяндорж гэгчийг Бат-Өлзий сумын Цагдаагийн хэсгийн алба хаагч нар 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Хархорин сумаас,
- 31.2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Тарагт сумын 6 багийн Олон дов гэх газар

оршин суух Ж.Бүрэнтөгс гэгчийн 3 тооны хонийг бусадтай бүлэглэн хулгайлсан эрүүгийн 201715000032 тоот хэрэгт сэжигтнээр татагдан шалгагдаж байгаад оргон зайлсан Дашдоржийн Батдож гэгчийг 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Ч.Цогтбаяр Арвайхээр сумын нутгаас тус тус баривчлан холбогдох албадад хүлээлгэн өгч ажилласан байна.

Бусад цагдаагийн газар, хэлтсээс эрэн сурвалжилж байсан оргодол эргээдүүдийг олж тогтоосон талаар

Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо иргэн Б.Бат-Очирын авто машины салхины шилийг хагалж хэргийн газраас оргон зайлсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан Алтанцэцэгийн Ганбат гэгчийг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Богд сумын 4 дүгээр багийн нутгаас хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч А.Даваадэмбэрэл олж тогтоон, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан Мандширын Бат-Амгаланг Архангай аймгаас цагдаагийн хошууч З.Мягмарсүрэн, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс эрэн сурвалжлагдаж байсан Идэрмөнхийн Баянжаргалыг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутгаас олж цагдаагийн дэслэгч Ц.Самдантүвдэн тус тус олж тогтоон холбогдох албадад хүлээлгэн өгсөн.

4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

Тус аймаг дахь цагдаагийн газар 2017 онд мал хулгайлах гэмт хэргийн 57 гомдол, мэдээллийг хүлээн авсан нь урьд онтой харьцуулахад 5 буюу 8.7 хувиар өссөн. Хүлээн авсан 57 гомдол мэдээлэлээс 41 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн шалгаж мөрдөн байцаах тасагт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай хүргүүлж илрүүлэлт 53.6 хувьтай байна.

Үйлдэгдсэн орон нутгаар нь авч үзвэл Хархорин суманд 8, Баян-Өндөр суманд 5, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Хужирт сумдад тус бүр 4, Тарагт суманд 7, Уянга, Арвайхээр сумд 6, Хайрхандулаан, Нарийнтээл сумдад тус бүр 1 мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэж бусад сумдад энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй.

Үйлдэгдсэн цаг, өдөр нь 06-14 цагт 3, 14-19 цагт 2, 19-22 цагт 4, 22-06 цагт 15 гэмт хэрэг үйлдэгдсэн ба даваа гарагт 6, мягмар гарагт 5, лхагва гарагт 3, пүрэв гарагт 1, баасан гарагт 5, бямба гарагт 4, ням гарагт 5 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Малын хулгайн 65 холбогдогчтой 51.621.000 мянган төгрөгийн хохирол учирсан 22 хэргийг илрүүлж ажилласан байна бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 41 хэргээс 22 хэрэгт ял сонгосон нь мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт урьд оны мөн үеээнхээс 10 хувь өссөн байна.

Мал хулгайлах гэмт хэргийн улмаас 51.621.000 төгрөгний хохирол учирч, 24 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан ажилласан. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд иргэдэд учирсан 25.300.000 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлж 25.600.000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж хохирол нөхөн төлүүлэх бололцоогоор хангаж ажилласан.

Өвөрхангай аймаг нь Засаг захиргааны 19 сум, 109 баг, 113991 хүн амтай, 33540 өрхтэйгээс хөдөөд 16837 өрхтэй, 62895 км² нутаг дэвсгэртэй, Монгол улсын төв хэсэгт оршдог. Тус аймгийн нутгийн хойд хэсэгт хангайн нурууны салбар уулс, төв хэсгээр нь хөндийн тал, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулс, элсэрхэг тал хээрийн нутагтай. Хойд хэсгээр Архангай аймгийн Хашаат, Цэнхэр сум Зүүн хэсгээр Булган аймгийн Рашаант, Төв аймгийн Эрдэнэсант сум, Зүүн урд хэсгээр Төв аймгийн Дэлгэрхаан, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Урд хэсгээр Дундговь аймгийн Сайхан-Овоо сум, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Булган сум, Баруун урд хэсгээр Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэврээ сум, Баянхонгор аймгийн Богд, Баянлиг сум, Баруун хэсгээр

Баянхонгор аймгийн Өлзийт, Баруун хойд хэсгээр Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумдадтай хил залган оршдог. Баруун аймгуудыг нийслэл Улаанбаатар хоттой холбосон хатуу хучилттай засмал замтай.

2017 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр нийт 5.644.063 мянган толгой мал үүнээс үхэр 294768 мянга, адуу 357970 мянга, тэмээ 28719 мянга, хонь 2613940 мянга, ямаа 2348666 мянга, нийт малтай өрх 18597 үүнээс малчин өрх 15847 тоологдсон байна.

Тус аймагт 2015 онд баригдсан “ӨВ МИЙТ ХХК” мал мах боловсруулах үйлдвэр баригдаж үйл ажиллагаа явуулалгүй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийж байгаад 2017 оны 11 дүгээр сарын 20-ноос үйл ажиллагаа явуулж байна.

Махны худалдаа эрхэлдэг “Занабазар” зах, “Малчид”-ын хоршоо, Өвөрхангай аймгийн Хархорин суманд “Эрдэнэзуу” зах, “Тод манлай” зах үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн төвд мал махны бөөний үнээр авч Улаанбаатар хотруу борлуулдаг 8 цэг, мал мах худалдан борлуулдаг 40 орчим ченж, малын гаралтай түүхий эд худалдан авдаг 75 орчим ченж, 8 түүхий эдийн төв үйл ажиллагаа явуулдаг.

Аймгийн хэмжээнд зуншлага Говийн сумдуудаар тааруу байсан тул говын сумдууд хангайн сумдаар оторлосон. Хархорин, Бүрд, Баян-Өндөр, Өлзийт, Есөнзүйл, Хайрхандулаан, Тарагт сумдын нутагт цас их хэмжээгээр унаж өвөлжилт хүндэрсэн тул Өвөрхангай аймгийн Сант, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Төв аймгийн Дэлгэрхаан, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Булган сумдын нутгаар отор хийж өвөлжилж байна.

2017 оны 01 дүгээр сард 3 сарын хугацаатай “Хулгай-2017” нэгдсэн арга хэмжээ, 2017 оны 04 дүгээр сарын 13-наас 2017 оны 06 дугаар сарын 01-ний хооронд “Алдуул мал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан үр дүнг тооцсон.

Хууль зүйн сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/160, А/73 тоот хамтарсан тушаалаар “Малчдын бүлэг”-ийн үлгэрчилсэн дүрмийг сум орон нутагтаа хэрэгжүүлэн урьд байгуулагдсан идвэх санаачлагагүй ажиллаж байгаа бүлгийг идэвхжүүлэх, шаардлагатай бол дахин байгуулах талаар албан бичгийг хүргүүлэн ажиллаж мөн сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт Хууль зүй, дотоод хэрэг, Хүнс хөдөө аж ахуйн сайдын хамтарсан 2007 оны 140/80 тушаалаар баталсан “Алдуул малыг бүртгэх, мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлэн, мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлыг тухай бүрд нь аймгийн Засаг даргын шуурхай хуралдаан дээр танилцуулан ажиллаж “Мал, мах бэлтгэх” гарал үүслийн гэрчилгээний журмыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад танилцуулахад Зөрчлийн ерөнхий хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судлаж хариу өгөхөөр мэдэгдсэн.

Аймгийн хэмжээнд мөрдөгдөх Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ хэрэглэх журмын төслийг боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулх зөвлөлийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглээр хийж гүйцэтгэх ажлаа эрчимжүүлэх малчдын шинэчилэн зохион байгуулсан сайн дурын бүлгүүдийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр мэдээлэл хүргүүлэн ажиллалаа.

Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл идвэхтэн малчидтай хамтран 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 15 хоногийн хугацаатайгаар Морин эргүүлийг хийж гүйцэтгэсэн нь малчидын талархлыг хүлээсэн сайн ажил зохион байгуулагдсан.

Цагдаагийн газраас санаачлан Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/533 дугаартай захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Автотээврийн төв, Хүнс хөдөө аж

ахуйн газар, Татварын хэлтэс хамтарсан “Хяналт шийдвэрлэлт-2017” нэгдсэн арга хэмжээг 30 хоногийн хугацаатай зохион байгуулан явуулж малын хулгайн гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлж Мал эмнэлэг ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллалаа.

2017 онд Мал эмнэлэг ариун цэвэр гарал үүслийн №01А гэрчилгээ 3000, №01Б гэрчилгээ 6300 олгогдсонд цагдаагийн байгууллагаас хяналтаа тавьж ажиллахад №01А Тэмээ 81, адуу 11136, хонь 31532, үхэр 3838, ямаа 19986 №01Б 115585 тн маханд олгосон байна. Гарал үүслийн гэрчилгээнд амьд малд зургийг тогтмол авч хяналтыг тавьж ажиллалаа.

Цагдаагийн газраас санаачлан ХСИС-тай хамтран Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдсэн 10 жилийн гэмт хэргийн криминологи судалгааг хийлгэж 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанаар гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "АЮУЛГҮЙ ИРГЭН- АМАР ТАЙВАН ӨВӨРХАНГАЙ" хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн батлууллаа.

Уг дэд хөтөлбөрт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тодорхой ажлуудыг тусгуулан ажилласан.

5. Нийтийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын хэмжээнд нийгмийн хэв журам, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 20753 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11907 буюу 2.3 дахин өссөн. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 1259 хүнийг саатуулж, 635 хүн баривчлан, 19.386 хүнийг 843.8 сая төгрөгөөр торгож, 731 хүний авто машин жолоодох эрхийг хасаж ажилласан нь өмнөх оноос торгож, эрх хасагдсан жолооч 397 буюу 2.1 дахин өсч, баривчлагдсан хүн 420 буюу 2.9 дахин, торгосон хүн 11089 буюу 2.3 дахин тус тус өсч, торгуулийн хэмжээ 471.4 сая төгрөгөөр буюу 2.2 дахин өсч, саатуулагдсан хүн 13 буюу 1.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Алба хаагчдаас ЗХТХ-ийн 24 зүйлийг үндэслэн 117 сэжигтэй этгээдэд үзлэг хийж 19 хутга мэс зодооны хэрэгсэл хурааж авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр:

Зам тээврийн хөгжлийн яам, Замын цагдаагийн албаны Орон нутгийн хяналтын хэлтэстэй хамтран Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр Тарнын уулзвараас Нарийнтээл сум хүртэлх 325 км, Тарнын уулзвараас Хархорин сум хүртэлх 77 км, Хархорин сумаас Хужирт сум хүртэлх 45 км замуудын эвдрэл, хар цэгүүдийн судалгааг хамтран гаргалаа.

2017 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослын шинжтэй нийт 118 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 50 гомдол мэдээллийг харьяалалын дагуу хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасагт шилжүүлж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 609 иргэний зөрчилд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиар шийтгэвэр, шийтгэлийн хуудсаар 243.600.000 төгрөгийн торгууль оногдуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, эрх хасагдсан буюу эрхийн үнэмлэхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 416 иргэнийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж ажилласан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах замын хяналт шалгалтаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 12859 жолоочид бэлэн бус торгуулиар 437.459.000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан.

2017 онд ХАБАЖЭГХэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 154 удаа

нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 49 аж ахуй нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулж, телевизээр 24 удаа, радиогоор 12 удаа мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг өгч, 3 удаа ухуулага сурталчилгааны ажлыг явуулж, хэрэг ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар 42 мэдэгдэл, шаардлага бичиж, 42 хариуг авч хариу авалт 100 хувь байна.

Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, хуваарийн дагуу “Эвдрэл гэмтэл-техникийн зөрчил”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө, үзэмж”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг хуваарийн дагуу зохион байгуулан ажилласан нь үр дүнтэй ажил болж, нас баралт буурсан үзүүлэлттэй, зөрчил илрүүлэлт өссөн үзүүлэлттэй байна.

Улсын чанартай авто замын дагуу байрлах Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын хэсгийн төлөөлөгч цагдаа нарыг цагийн менежмент хуваарийн дагуу давхцуулалгүйгээр эргүүлд гаргаж аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа замуудыг байнгын хяналтанд байлгаж Архангай аймгийн Хашаат сумын нутагт байрлах байнгын постонд Архангай аймгийн Цагдаагийн газрын алба хаагчидтай сар сараар ээлжлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд сурталчилах, замын цагдаагийн тасгаас зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Увс аймаг дахь Цагдаагийн газар, Замын цагдаагийн албаны “Орон нутгийн замын цагдаа”, “Увс Замын цагдаа” Facebook, сайтуудад “Сар шинийн баярын мэнд хүргэе, Замын хөдөлгөөний дүрмээ баримталж, бусдыг хүндэтгэн замын хөдөлгөөндөө соёлтой оролцоё”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг таслан зогсооё”, “Хамгаалах бүс таныг хамгаална” зэрэг санамж, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээлэл 64 удаа байршуулж ажилласан.

Орон нутгийн, улсын чанартай авто замуудын тэмдэг, тэмдэглэгээнд хяналт шалгалт хийх удирдамж гарган аймгийн засаг даргаар батлуулж, 2017 оны 02 сарын 25-наас 03 сарын 23-ны хооронд Мэргэжлийн хяналтын газар, АЗЗА ТӨҮГ, Автотээврийн үндэсний төвийн байцаагч нартаа хамтарсан шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах, засварлуулах саналыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүллээ.

Цагдаагийн Ерөнхий газрын Замын цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Даваазулаас 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу аймгийн засаг даргын 2017 оны 03 сарын 21-ний өдрийн А/133 дугаартай “Аймгийн нутаг дэвсгэрт орон нутгийн болон улсын чанартай авто замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Дээрх захирамжийн дагуу 2017 оны 05 дугаар сард Замын цагдаагийн албаны Орон нутаг хөдөлгөөний хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн цагдаагийн дэд хурандаа Б.Алтансүх, техник замын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Р.Цогтоо, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Аймгийн мэргэжлийн хяналтын газар, “ӨВА АЗЗА” ТӨХК-ны ажилтан алба хаагч нарын бүрлэдэхүүнтэйгээр А0301, А0302 тоот автозамуудын тэмдэг, тэмдэглэгээ, эвдрэл гэмтэлд үзлэг шалгалтыг 2 удаа хийж ажилласан.

Тухайн автозамуудад шаардлагатай байгаа

Анхааруулах тэмдэг-232

Мэдээлэх тэмдэг-20

Хориглох-121

Түмбэ-221

Мэдээллийн самбар-4

Км-ийн заалт-203 зэрэг тэмдэг, замын байгууламжийн саналыг холбогдох газруудад хүргүүлсэн.

Гүүр давааны тэмдэг 35 ширхэгийн судалгааг Зам тээврийн хөгжлийн яам, Замын цагдаагийн албаны техник замын хяналтын хэлтэс, аймгийн удирдлагад хүргүүлэн ажиллаа.

Албаны галт зэвсэг тусгай хэрэгслийн талаар:

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын даргаас ирүүлсэн ажлын чиглэлийн хүрээнд газрын даргын 2017.01.06-ны өдрийн А/01 дугаартай тушаалаар “Албаны галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгсэлд үзлэг тооллого явуулах тухай” ажлын хэсэг байгуулан хийгдэх ажлын төлөвлөгөө гарган заалт бүрийг хариуцах алба хаагчийг томилон хяналт шалгалтыг 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 30-ны хооронд зохион байгуулав. Тусгай хэрэгслийн бүртгэл, тооллогыг санхүүгийн баримтанд тулгуурлан нэг бүрчлэн тоолж шалгахад 47 нэр төрлийн эд зүйлс бүртгэлээр данслагдсан. Газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн албаны галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийн тооллогын үр дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж, ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа тусгай хэрэгслүүдийг актлаж, устгуулах шийдвэр гаргуулах, улмаар цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж хяналт шалгалтыг тогтмолжуулан ажилласан байна. Тусгай хэрэгслийн бүртгэл, тооллогыг санхүүгийн баримтанд тулгуурлан нэг бүрчлэн тоолж шалгахад зөрчил дутагдал илрээгүй байна. Аймгийн үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгуулагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Марш тактик”-ийн аварга салаа шалгаруулах тэмцээн, буудлагын тэмцээнүүдэд 1 ширхэг ПМ маркын буу, 10 ширхэг АКМ, АКМС буу Цагдаагийн газрын даргын тушаалаар алба хаагч нарт тавьж олгон тэмцээнд оролцож дуусаад галт зэвсгүүдийг галт зэвсгийг хурааж авсан.

Цагдаагийн газрын албаны галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгсэлд журмын дагуу 2 удаа үзлэг, тооллого хийж, хадгалалт хамгаалалт хариуцсан алба хаагчдын үйл ажиллагаа, байр, агуулахын, бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавин 24 цагийн хяналтын камераар тоноглогдсон өрөөнд хамгаалж байна. Галт зэвсгийн өрөөг шинээр засварлан 2 ширхэг камер, цонх, хаалганы хамгаалал, бэхэлгээг сайжруулсан. Галт зэвсэгтэй үүрэг гүйцэтгэх Монголбанкны хэлтэст үүрэг гүйцэтгэх алба хаагчийн галт зэвсэг, тусгай хэрэгсэлд байгууллагын жижүүрийн шуурхай албаны ажилтнууд, ёс журам сахиулах эргүүл, хариуцлагатай эргүүлүүд өдөр хяналт тавьж газар дээр нь шалган зааварчилж ажиллав.

Олон нийтийн цагдаагийн ажлын талаар:

Олон нийтийн цагдаагийн ажилтнаар ажиллаж байсан ажилтны хөдөлмөрийн гэрээг дүгнэн “А”, “В” дүгнэгдсэн олон нийтийн цагдаа нарын хөдөлмөрийн гэрээг сунган ажиллуулж байна. 2017 онд Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан 2 иргэнийг сумдын Засаг даргын саналыг үндэслэн цагдаагийн газрын даргын тушаалаар “Олон нийтийн цагдаагийн ажилтан”-аар томилон, хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллуулж байна. Аймгийн Засаг дарга, ИТХурлаас томилогдон ажиллаж байгаа 10 олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, урамшуулалд 2017 онд 33300.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Олон нийтийн цагдаагийн ажилтанг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ажлын хүрээнд 03 дугаар сарын 16-ны өдөр аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс зохион байгуулсан нэгдсэн сургалтанд хамрагдаж, шинээр батлагдан гарсан хууль тогтоомжуудын талаар мэдээ, мэдээлэл өгсөн.

Аймгийн төвд ажиллаж байгаа 6 олон нийтийн цагдаагийн ажилтны ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулан Арвайхээр сум хариуцсан хэсгийн байцаагч нарт

хариуцуулан баг тус бүр дээр багийн цагдаа нартай хамтран ажиллаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээг долоо хоног бүр зохион байгуулж, хуулиар харъяалуулсан зөрчилд торгууль ногдуулан ажиллаж байгаа бөгөөд 1 дүгээр улирлын байдлаар зөрчил гаргасан 11 иргэнд 55.5 мянган төгрөгийн торгууль ногдуулсан нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 10.0 мянган төгрөгийн торгуулиар буюу 2 зөрчлийн шийдвэрлэлтээр ахиулсан үзүүлэлттэй байна.

Тасгийн дарга, ахлах байцаачгаас 7 хоногт 1 удаа олон нийтийн цагдаа нартай уулзаж, үүрэг, ажлын чиглэл өгч, хийсэн ажлын мэдээг 7 хоног бүр авч, цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, цаашид хийх ажлыг тодорхойлон үйл ажиллагааг нь иргэд олон нийтэд сурталчлан ажилласнаар олон нийтийн цагдаагийн ажилтны ажил үүрэг гүйцэтгэх, хууль, эрх зүйн мэдлэг нь сайжирсан байна. **“Аюулгүй хот-Цэвэр орчин”** 3 сарын аяныг санаачлан явуулсан бөгөөд Арвайхээр сумын 1-ээс 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт Арвайхээр хотын иргэд болон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын дарга захирал, ажилчид, төрийн алба хаагчид нийгмийн хариуцлагаа ухамсарлах, аюулгүй амгалан ая тухтай амьдрах, цэвэр орчин бүрдүүлэх, Аймгийн ИТХ-аас гаргасан тогтоол, Аймаг, сумын Засаг даргын захирамж тогтоолыг тухай бүрд нь хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон нийтэд тайлбарлан таниулах, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж, гудамж талбай бохирдуулж хог угаадас асгасан, нохой нь уяагүй сул гудамжинд явж байгаа айл өрхүүдэд эхний удаа сануулга өгч ажилласан.

Олон нийтийн цагдаа нар нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын 30 сургуулийн 11.852 сурагчдын дунд төрийн болон төрийн бус 12 байгууллагатай хамтарсан уулзалт, өдөрлөг, сургалтыг зохион байгуулж, "School police"-ийн эргүүлээр ажилласан 1860 эцэг, эхчүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ерөнхий боловсролын 10 сургууль орчмын авто зам, уулзвар, гар хэсгүүдэд тодорхой цагт давхардсан тоогоор авто эргүүлийн 32, явган эргүүлийн 19 чиглэлд цагдаагийн алба хаагчтай хамтран хяналт тавьж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд 6500 ширхэг, аж ахуйн нэгж, байгууллагад 410 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараажээ. Мөн цагдаагийн алба хаагчтай хамтран 2 гэмт хэрэг илрүүлж, зөрчил гаргасан 50 иргэнд 270.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж, 180 аж ахуй нэгж байгууллага 215 албан мэдэгдэл, зөвлөмж хүргэж, 19 хэргийн газрын хамгаалалтад ажиллаж давхардсан тоогоор цагдаагийн 75 алба хаагч, 21 хэсгийн ахлагч, багийн идэвхтэн, цагдаагийн 2 ахмад ажилтануудтай хамтарсан эргүүлд гарч, 13759 иргэнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулжээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цахим тоглоомд донтохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг-2400, “Амь нэгтэй хөршүүд” зурагтай гарын авлага-1250, “Халаасны хулгайчаас болгоомжил”-1260, “Нохойн санамж”-5000, “Гэр, орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”-4250, “Мотоциклийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” 700, Малчдад “Ноолуурын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” 200, Замын зөрчлийн заалтуудыг оруулсан санамж 600 ширхэг иргэдэд түгээж иргэн олон нийтийн хамтын ажиллагааг дээшлүүлэхэд ихээхэн үр дүнтэй ажилласан.

Мөн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 43 зөрчил, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 19 зөрчил, мал мах гарал үүслийн бичиггүй 8 зөрчлийг илрүүлсэн. Зөрчлийн тухай хуулийн хүрээнд холбогдох хуулийн заалтуудаар шийтгэлийн хуудсаар торгууль ногдуулах талаар хуульчилж өгсөн боловч РУК код нь ирээгүй. Иймд ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах төв, Хуулийн хэлтэс, НХЖХГ-ын даргаас тус тус санал тавьж энэ талаар тодруулсан боловч тодорхой шийдвэргүй хүлээлтийн шатанд байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр харьяа сумдын хэлтэс, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, байцаагч нарт 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 45/47, 45/69 албан бичгээр үүрэг, ажлын чиглэл, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг шалгах аргачлал 2 удаа, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль сурталчилах ажлын төлөвлөгөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2017 онд хийх ажлын төлөвлөгөө, олон нийтийн 8 цагдаагийн ажилтанд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн зааварчилга хүргүүлж, биелэлтийг сар бүр тооцож, сумдад мэдээлэл болгон хүргүүлэв.

Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, нийт алба хаагч нарт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэглэх ур чадвар олгох”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”, 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”, Улсын ерөнхий прокурор, Хууль, зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22, А/31 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам” зэрэг сэдвээр 8 сургалтын материал бэлтгэж, албаны сургалтыг 4, зайны сургалтыг 12 удаа 120 алба хаагчийг хамруулан зохион байгуулсны үр дүнд алба хаагчдын мэдлэг, хууль хэрэглэх ур чадвар дээшилсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд иргэний үүрэг, хохирогчийн эрх, зөрчил гаргагчид хүлээлгэх хариуцлагын талаар орон нутгийн 3 телевиз, 1 сонин, 1 сэтгүүлд 2017 онд давхардсан тоогоор 56 удаа мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж иргэд олон нийтэд хууль сурталчилах ажлыг зохион байгууллаа. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилах чиглэлээр Хужирт сумын 12 аж ахуй нэгж, 280 орчим иргэдэд Соёлын төвтэй хамтран “Эр хүн танаа-2017” арга хэмжээг удирдамжийн дагуу 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа.

Хүүхдээс үйлдэгдэж буй гэмт хэргийн 66 хувийг эзэлж буй бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс өсвөр үе, хүүхэд залуучуудыг урьдчилан сэргийлэх, тэдэнд зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор “Хулгайчид гишгэх газар үгүй” сэдэвт гар зураг, зохион бичлэг, шүлгийн уралдааныг 2017.04.20-05.20-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулан аймгийн 14 сургуулийн 687 сурагч хамрагдаж, шагналт байр эзэлсэн 15 хүүхдийг шагнаж урамшуулав.

Арвайхээр чөлөөт суваг телевизтэй хамтран “Сургуульдаа хүрэх замд”, “Чөлөөт цаг” зэрэг 7-10 минутын нэвтрүүлэг бэлтгэж, хүүхэд залуучуудад хүргэсэн. ЕБС-ын анги удирдсан багш нарт 8 төрлийн сургалт, мэдээлэл хүргүүлж, 2016-2017 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 156 удаа сургалт зохион байгуулснаар гэмт хэрэгт холбогдсон сурагчдын тоо 46.3 хувь буурсан байна.

ЕБСургууль дээр 2016-2017 оны хичээлийн жилд хэрэгжсэн эцэг эхийн эргүүлийн тайланг авч, 3 сургуулийг шалгаруулсан. Аянд ерөнхий боловсролын сургуулийн “өсвөрийн цагдаа”, “өсвөрийн аврагч”, “өсвөрийн сурвалжлагч”, “номын анд”, “ангийн дарга нарын нэгдэл”, “нэгдмэл ертөнц” зэрэг хүүхдийн өөрөө удирдах 13 байгууллагын 400 гаруй сурагчид оролцлоо.

Хүүхдүүд гэр бүлдээ сайн сайхныг хүсэж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж, хүчирхийлэлгүй, тайван орчинд амьдрах хүсэл тэмүүлээ илэрхийлж, Арвайхээр сумын төв талбайгаар парад алхалт хийсэн юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө өгөх 7032-3-102 дугаарын утсыг ашиглалтанд оруулж “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 25-р зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэн 42 иргэнд зөвлөгөөг өгсөн.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

“Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанаар архидалттай тэмцэх “Мэргэжлийн баг”-ийн төлөвлөгөө, төсөв зардлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, мөн 19 суманд энэ багийн байгуулах ажлыг эхлүүлэн нийт 22 “Аддиктологийн баг”-ийг байгуулсан. Аймгийн Засаг дарга А/561 дугаар захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн цагийн хуваарийг өөрчлөн батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр олон ажил арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд энэ оны байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 79 бүртгэгдэж, урд оны мөн үеэтэй харьцуулахад 38.7 хувь буурсан аймаг орон нутгаас явуулж байгаа бодлогыг дэмжиж, хамтран ажласны үр дүн юм.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагааны чиглэлээр:

2017 онд аймгийн сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн шийдвэрээр захиргааны зөрчил гаргасан 537 хүнийг баривчлуулж, эрүүлжүүлэх, саатуулах байранд 1124 хүнийг хүлээн авч эрүүлжүүлж, эрүүл мэндэд нь хяналт тавьж, хөтлөгдвөл зохих бүртгэл, судалгаануудыг хөтлөж ажиллаж ба шинээр батлагдсан 3 журмын хэрэгжилтийг хангаж, жижүүрийн офицер, ёс журам сахиулах эргүүл, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, тасгийн даргаас өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна.

Эрүүлжүүлэгдсэн нийт 1124 иргэний 1100 хүнээс 4.101.200 төгрөгийн төлбөрийг, баривчлагдсан 537 хүнээс 9.441.590 төгрөгийн зардлын тооцоог эмч нар хураан авч санхүүд баримтаар хүлээлгэж өгсөн ба төлбөр барагдуулах ажилд дээр эмч нар идэвхи санаачлагатай ажиллаж байна. Энэ онд Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны эмч, жижүүр, бие засах өрөө, сургалтын өрөөнд 1.5 сая төгрөгийн урсгал засварыг хийсэн. Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан, саатуулагдсан этгээдүүдийн талаар фото зураг, биеийн байцаалтын мэдээллийг харуулсан сан шинээр бий болгож архивийн нэгж үүсгэн ажиллаж байна.

Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслэлийн эргэлтэд хяналт тавих талаар:

Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслэлийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн дагуу Улаанбаатар хотоос Ховд аймгийн Хөшөөт, Дарив Баянхонгор аймгийн Баяновоо, Говь-Алтай аймгийн Цээл сумд руу хүнд даацын 53 автомашинаар 997.6 тонн тэсрэх бодис тээвэрлэн аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 71 алба хаагч ажиллан зөрчил дутагдалгүй дамжин өнгөрүүлсэн байна. Нарийнтээл сумын 2 дугаар багт байрлах нүүрс олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Баянтээг” ХК-д хугацаа дууссан тэсрэх бодис дагалдах хэрэгслийн хамт 2 төрлийн складанд хадгалагдаж байсан бөгөөд 2017.03.30-ны өдрийн 14.00 цагт аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын өрөөнд хугацаа дууссан тэсрэх бодисыг шийдвэрлүүлэх, устгах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан уулзалтын үеэр хэрхэн шийдвэрлэх чиглэлээр хуралдаж аймгийн Засаг даргад саналыг хүргүүлсэн байна. 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 18-ны хооронд хугацаа дууссан тэсрэх бодисыг устгах шийдвэр гарсантай холбогдуулан 10 хүнтэй ажлын хэсгийн бүрэлдэхүүн “Баянтээг” ХК-ний тусгай бэлтгэсэн талбайд хугацаа дууссан 6.6 тонн анфо тэсрэх бодисыг 11 метрийн гүнтэй 140 ширхэг цооногт хийж утсгав. Тэсрэх материалтай харьцах, тэсрэх материалыг тээвэрлэх, устгах ажил явуулах үед эрсдлээс урьдчилан сэргийлэх нарийвчилсан ажлын төлөвлөгөөний дагуу аюулгүй байдлыг хангаж хэв журмын хамгаалалтанд 3 алба хаагч ажилласан.

Өнөөдрийн байдлаар тэсрэх бодисны үлдэгдэлгүй байна.

Захиргааны хяналтын талаар:

Захиргааны хяналтанд 124 этгээд байснаас этгээд хугацаа дууссан үндэслэлээр хяналтыг зогсоож, 16 этгээд шинээр хяналтанд орж, одоогоор 108 этгээдэд захиргааны хяналт тогтоон ажиллаж байна. Энэ хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн 1, захиргааны хяналтад байгаа этгээдүүдтэй сар бүр уулзан, дахин давтан гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх талаар зөвлөгөө өгч, баталгаа гаргуулан авч, хувийн хэрэгт баяжилт хийн, аймгийн Прокурорт тогтмол хянуулан зөрчил дутагдал заагдаагүй болно.

Нийтийн хамарсан арга хэмжээ, гамшгаас урьдчилан сэргийлэх талаар:

Мэргэжлийн ангиудтай хамтарсан дадлага, сургуулилтыг Арвайхээр сумын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 16.00 цагт зохион байгуулсан ба давхардсан тоогоор 74 алба хаагч, 12 иргэд, баривчлагдсан 4 хүнийг аюулгүй газарт шилжүүлж, байрлуулсан бөгөөд ирцийн бүртгэлээр бүх алба хаагчид, иргэд, баривчлагдсан, саатуулагдсан иргэд бүрэн ямар нэгэн бэртэл гэмтэлгүй байлаа. Мөн Монгол банкин дээр гамшиг осол гарсан үед ажиллах, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг 04 дүгээр сард Онцгой байдлын газар, бусад төрийн байгууллагын мэргэжлийн ангиудтай хамтран зохион байгуулж үнэлэлт дүгнэлт өгөв. Энэ дадлага сургуульд цагдаагийн газраас 12 алба хаагч оролцов. “Номхон далайн бүс нутгийн улс орнуудын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх нь сэдэвт “Говийн чоно 2017” “Гамшгийн хор уршгийг арилгах дасгал сургууль туршлага солилцох үйл ажиллагаа Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны хооронд говийн 5 аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн ангиудын 50 ажилчин алба хаагч, гадаадын 9 улсын гамшгаас хамгаалах алба хаагч нар оролцож хамтарсан баг болж танхимийн болон хээрийн сургалт дадлагад ажиллаж туршлага солилцлоо. Аймгийн хэмжээнд хүн малын гоц халдварт өвчний чиглэлээр 9, 13 удаагийн үер, 41 удаагийн объектын түймэр, техникийн осол 1 бүртгэгдэж, холбогдох байгууллагуудтай хамтран 64 удаа 126 алба хаагч ажилласан байна.

Цагдаагийн газраас жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, террорист халдлага гарсан үед ажиллах төлөвлөгөө, онцгой нөхцөл байдал бий болсон үед харилцан хамтран ажиллах төлөвлөгөө, гамшиг, хорио цээрийн дэглэмийн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах дэг журам сахиулах төлөвлөгөөний хүрээнд дээрх нөхцөл байдал үүссэн үед ЦЕГ-ын даргын 2016.06.14-ний өдрийн “Шуурхай удирдлагын болон шуурхай штабын бүрэлдэхүүн, түүний ажиллах чиг үүргийг батлах тухай” Б/311 дугаар тушаалаар баталсан цагдаагийн газрын шуурхай штаб ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тодотгол хийв. Аймгийн хэмжээнд жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, террорист халдлага гарсан үед ажиллах төлөвлөгөө, онцгой нөхцөл байдал бий болсон үед харилцан хамтран ажиллах төлөвлөгөө, гамшиг, хорио цээрийн дэглэмийн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах дэг журам сахиулах төлөвлөгөө зэргийг шинэчлэн гарган батлуулж биелэлтийг хагас, жилээр гаргаж ажилласан.

Террорист халдлага гарсан үед ажиллах төлөвлөгөөний хүрээнд аймаг дахь Тагнуулын хэлтсээс ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу Арвайхээр сумын 5-р багт байрших Мэргэд цогцолбор сургуульд “Хүүхэд барьцаалсан”, “Төв усан санд химийн хорт бодис хийж хордуулсан” 2 өгөгдөлд цагдаагийн газраас ажиллах төлөвлөгөөний загварыг нууцлал ханган ажилласан. Аймгийн Онцгой байдлаас 2017 оны 04-р сарын 01-ний өдөр Арвайхээр сумын төвд зохион байгуулсан гамшигаас хамгаалах дадлага сургалтад тус газрын алба хаагч нар хамрагдсан, мөн 2017 оны 11-р сарын 21-ний өдөр Аймгийн онцгой байдлын газар, шүүх, прокурорын газартай хамтран байгууллагын объектод гал гарсан үед алба хаагчдыг аврах ажиллагаа явуулах талаар хамтарсан

сургалтыг зохион байгуулав

Шүүхийн байранд харуулын 4 цагдаа 24 цагаар 8760 цагийн үүрэг тасралтгүй гүйцэтгэж, хэсгийн даргаас алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтэнд өдөр тутмын хяналт тавьж ажиллаж, алба хаагчид шүүхийн байранд шүүх хуралд оролцох, шүүхээр үйлчлүүлэхээр нэвтэрсэн 3560 иргэний бичиг баримтыг шалган бүртгэж, энгэрийн зүүлтийг өгч овор ихтэй эд зүйлд үзлэг хийж, эд зүйл хадгалах шүүгээнд хадгалуулж шүүхийн байранд нэвтрүүлж аюулгүй байдлаа хангаж ажилласан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Арвайхээр сум дахь сум дундын шүүхэд эрүүгийн хэргийн шүүх хурал 377, иргэний шүүх хурал 489, захиргааны хэргийн шүүх хурал 19, захиргааны зөрчлийн шүүх хурал 318, Хархорин сум дахь сум дундын шүүхэд эрүүгийн хэргийн шүүх хурал 111, иргэний хэргийн шүүх хурал, 248, магадлангын шүүх хурал 347, захиргааны зөрчлийн шүүх хурал 94 болж, шүүх хуралдааны дэг журам сахиулж ажилласан байна. Шүүх хуралдааны дэг сахиулах ажиллагаанд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй нөхцөл байдал тайван байсан болно. Шүүх хуралдаанд давхардсан тоогоор шүүгч 1601, улсын яллагч 598, нарийн бичгийн дарга 1214, өмгөөлөгч 561, хохирогч 434, шүүгдэгч 592, иргэний хариуцагч 333, нэхэмжлэгч 502, зөрчил гаргагч 318, шинжээч 4 тус бүр оролцсон байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажилд шаардлагатай шүүгдэгч, яллагдагчийг түр саатуулах байртай болгох, шүүхийн харуулын байранд дээр согтуурал хэмжих багажтай болгох, нөөц гарцтай болох, шүүх, шүүхийн байр орчины хяналтын камеруудыг бүрэн ажиллагаатай болгох, шаардлагатай цэгүүдэд нэмэлт камер суурьлуулах, шүүхийн иргэний хурлын танхимыг 1-р давхарт оруулж, шүүгч нарын албан тасалгааг 3-р давхарт нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудлаар 2016 оны 11 дүгээр сард тус шүүхийн тамгын газарт хүсэлт хүргүүлж, 2017 онд шүүхийн тамгын газартай хамтран ажиллах төлөвлөгөөнд дээрхи асуудлуудыг шийдвэрлэхээр тусгаж ажиллаа. 2017 онд төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас нөөц гарцтай болох, шүүх, шүүхийн байр орчины хяналтын камеруудыг бүрэн ажиллагаатай болгох, шүүхийн иргэний хурлын танхимыг 1-р давхарт оруулж, шүүгч нарын албан тасалгааг 3-р давхарт нүүлгэн шилжүүлэх зэрэг ажлууд бүрэн шийдвэрлэгдэж, шаардлагатай цэгүүдэд шинээр камер суурьлуулах, согтууруулах хэмжих багажтай болох, шүүгдэгч, яллагдагчыг түр саатуулах байртай болох асуудал шийдвэрлэгдээгүй байна. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын шүүхийн байранд шинээр засвар үйлчилгээ хийгдэж хамгаалалтын камерын системийг хуучин дотор 10, гадна 4 камер байснаас шинээр 8 камерыг нэмж суурилуулж, гадна орчинд гэрэлтүүлэгтэй камерыг шинээр суурилуулж, серверийн өрөө, архивын өрөөг камержуулсан байна. Шүүхийн байрны 1, 3 давхруудад засвар үйлчилгээ хийгдэж, эрүүгийн болон иргэний шүүх хурлын 2 танхимыг засварлаж, шүүгчийн зөвлөлдөх тасалгааг дуу чимээ тусгаарлагчаар бүрэн тохижуулсан. Мөн шүүхийн байрны 2, 3 давхарт хамгаалалтын кодтой шилэн хаалга хийгдэж шүүхийн байрны 3-р давхарт зөвхөн шүүгч нарын өрөөг байхаар тохижуулсан нь шүүхийн байр болон шүүгчийн ажиллах аюулгүй байдлыг хангасан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

Цагдаагийн газраас 2017 онд Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад яам, агентлагт 1, аймгийн засаг даргад 7, аймгийн ГХУСАЗСЗ-д 11, сум, багийн засаг даргад 4, сумдын ГХУСАЗСЗ-д 11 нийт 45 ажлын санал бүхий 34 удаагийн танилцуулга хүргүүлж, 89,4 хувийг шийдвэрлүүлсэн байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгуулагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн санал, танилцуулгыг үндэслэн харьяа Иргэдийн төлөөлөгчдийн хурал, ГХУСАЗСЗ-ийн тогтоол 5, Засаг даргын захирамж 2, хөтөлбөр 1, албан даалгавар 1, бусад 2 шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал:Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас санаачлан “Зам тээврийн осол хэргийг бууруулахад бүсийн аймгийн хамтын ажиллагаа” сэдэвт хамтарсан зөвлөгөөний үеэр гарсан зөвлөмжийг Монгол улсын Хууль зүйн яам, бүсийн аймгуудын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 41 дүгээр “Зөрчлийн улмаас түр саатуулагдсан мотоциклын эзэмшигчидэд нь буцаан олгох тухай” тогтоолыг гаргуулан “Мотоцикль” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд байгаа 200 гаруй мотоциклиудыг эзэдэд нь хүлээлгэн өгөх ажлыг амжилттай зохион байгуулсан.

ГХУСАЗЗ, дэд зөвлөл, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал: Тус аймгийн ГХУСАЗСЗ-ийн хурлаар 5, сумдын ГХУСАЗСЗ-ийн хурлаар 22, нийт 27 асуудлыг хэлэлцүүлэв. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гаргасан шийдвэр: Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгуулагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн санал, танилцуулгыг үндэслэн харьяа Иргэдийн төлөөлөгчдийн хурал,ГХУСАЗСЗ-ийн тогтоол 5, Засаг даргын захирамж 2, хөтөлбөр 1, журам 1, бусад 2 шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх 8 заалт бүхий салбар төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллав. 2017 оныг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” жил болгон зарласан. Энэ ажлын хүрээнд аймгийн Боловсрол соёлын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан үр дүнг дүгнэж ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд аймгийн Засаг дарга, ГХУСАЗЗ-с 56,180,000 /Тавин зургаан сая нэг зуун наян мянган төгрөг/-ийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна. Замын цагдаагийн тасагт аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдээс “Police reader”, 10 сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Бэлэн бус торгуулийн машин” төхөөрөмж дөрвийг 56.180.000 /Тавин зургаан сая нэг зуун наян мянган төгрөг/-ийг шийдвэрлүүлсэн байна

2017 оны 10-р сарын 31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар криминологи судалгааны багийн ажлын хэсгийг томилж, аймгийн хэмжээнд анхаарал татаж байгаа, урьд оны мөн үеэс өссөн хэргүүдэд холбогдох судалгааг гаргаж, тасгуудад зөвлөмж, мэдээлэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр үнэлэлт дүгнэлт өгч ажиллав.

Аймгийн засаг даргын захирамжийн дагуу аймгийн Онцгой байдлын газар, мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Хөдөө аж ахуйн газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтран Хяналт-Шийдвэрлэлт нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 1 сарын хугацаатай зохион байгуулав. Аймгийн засаг даргын захирамжийн дагуу Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсооё нэгдсэн арга хэмжээг 3 сарын хугацаатай зохион байгуулан, арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулан олон нийтийн эргүүлийг зохион байгуулан ажиллав.

Арвайхээр сумын ИТХ-ын 26 дугаар тогтоолоор “Хөршийн холбоо” байгуулах журмыг хэрэгжүүлж, энэ ажлын хүрээнд “Хөршийн холбоо”-ны гишүүдтэй уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж “Итгэлцэлийн гэрээ” байгуулан хамтран ажиллаж байна.

Дээрх иргэдийг баг, хороон дээр ажиллуулсанаар гудамж, талбайд үйлдэгдэгдэх гэмт хэргийн гаралт энэ оны байдлаар 29,7 хувиар буурсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр салбар төлөвлөгөө гарган үр дүнтэй явуулж байгаа ажил арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Хужирт сум дахь цагдаагийн тасаг, Бат-Өлзий, Уянга сум дахь цагдаагийн хэсэг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт төлөвлөгөөг хүргүүлж, “Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Мотоциклийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэе” зэрэг сэдэвт санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өнгөт болон наалттай фото цаасан хэлбэрээр 250 ширхэгийг хэвлэн аймгийн төв дэх хүнс барааны зах, худалдааны төвүүд, ус түгээх худаг, автобусны буудал зэрэг нийт 125 цэгт байрлуулж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэв.

Арга хэмжээний хугацаанд “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэе” сэдэвт ауди болон үгэн сэрэмжлүүлгийг аймгийн “Арвайхээр”, “Соёмбо” телевизээр өдөрт 4 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудад өсвөрийн цагдаа бүлгэмийн гишүүдтэй хамтран эргүүл, хяналтыг зохион байгуулах, сурагчдад хулгайн гэмт хэргийн хор уршиг, үр дагаварын талаар сурталчлан таниулж, нийт 100 ширхэг сэрэмжлүүлэг тараах зэрэг ажлыг зохион байгуулсанаар сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 11351 хүнд 537.436.000 төгрөгийн бэлэн бус торгууль оногдуулсанаас аймгийн төрийн санд 310.881.225 төгрөгийн орлого төвлөрч 22.654.775 төгрөг төлөгдөөгүй байгаа учир орон нутгийн төсөвт төвлөрүүлэх авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдолын төлбөр орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлого хураалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар албан мэдэгдлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын “а”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөр батлах тухай 15 дугаар тогтоолыг үндэслэн “Иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, зам тээврийн осол хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулахад төр, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсооё” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд олон нийтийн эргүүлээр ажиллах, байгууллага, аж ахуйн нэгжийн 2-оос доошгүй албан хаагчдыг нэгдсэн зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөнөөс үүсэх хор, уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа нөлөөлөлийн ажлыг иргэд, олон нийтэд хүргэж ажилласанаар иргэдийн сэтгэлээ хандлага өөрчлөгдсөн үр ажил болж байна. Энэхүү ажлын хүрээнд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 500 гаруй жолоочийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1-д зааснаар арга хэмжээ оногдуулсан хэдий ч нөгөөтэйгүүр тэднийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэнд, эд хөрөнгийг нь хамгаалж чадсан эерэг үр дүнгүүд харагдаж байна.

2017 оны 04 дүгээр улиралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу тухайн шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт 153.775.000 /Нэг зуун тавин гурван сая долоон зуун далан таван мянга төгрөг/-ийг төвлөрүүлсэн /үүнээс цагдаагийн байгууллага 21.180.000 /Хорин нэгэн сая нэг зуун наян мянган төгрөг/-ийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан.

Үүнээс: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд аймгийн Засаг дарга, ГХУСАЗЗ-с 56.180.000 /Тавин зургаан сая нэг зуун наян мянган төгрөг/-ийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна.

Замын цагдаагийн тасагт аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдээс “Police reader”, 10 сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Бэлэн бус торгуулийн машин” төхөөрөмж дөрвийг 56,180,000 /Тавин зургаан сая нэг зуун наян мянган төгрөг/-ийг шийдвэрлүүлсэн байна.

Энэ оны томоохон ажлуудын нэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлуулж, үр дүнг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх” чиглэлээр Хууль Сахиулах Их Сургуулийн Криминологи судалгаа, мөрдөх албаны тэнхимтэй хамтран ажиллаж байна.

Судалгааны зорилго нь Монгол Улсын Их хурлаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд суурь хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулж, Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг криминологийн шинжлэх ухааны үүднээс үнэлж, дүгнэн цаашид орон нутгийн хэмжээнд шинжлэх ухааны үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Судалгааны ажлын хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралд Хууль сахиулах Их сургуулийн мөрдөх албаны тэнхимийн багш Л.Цогтбаяр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн судлаачид хүрэлцэн ирж, судалгааны ажлын явцын тайлан, 32 заалт бүхий зөвлөмжийг танилцуулсан.

Энэхүү судалгааны ажил хийгдсэнээр гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс шинжлэх ухааны үр дүнд бодиттой тодорхойлогдож, санал, зөвлөмж бүхий судалгааны тайлан боловсруулагдан, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бодит ахиц гарах үр дүнтэй юм.

Мөн Өвөрхангайчуудын санал, санаачлагыг тусгасан “Таны санал-төрийн шийдвэрт” “Харилцах дэвтэр”-ийг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд аймгийн 19 сум, 109 баг, Арвайхээр хотын төр, захиргаа, хувийн хэвшлийн 82 байгууллагад 300 дэвтрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумдын ГХУСАЗ салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулан аялуулж 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс сумд, байгууллагуудаас татан төвлөрүүлж дэвтэрт ирүүлсэн саналыг нэгтгэхэд давхардсан тоогоор 13500 иргэнээс 9054 санал бичигдсэнээс хамгийн олон удаагийн давтамжтай ирүүлсэн эхний 10 саналыг эрэмбэлэн гаргаж, аймгийн ИТХурал, Засаг дарга нарт танилцуулсан.

Дээрх криминологи судалгааны дүгнэлт, Харилцах дэвтрийн саналд ирүүлсэн иргэдийн саналыг үндэслэн 2018 онд “Аюулгүй иргэн амар тайван Өвөрхангай” хөтөлбөр хэрэгжүүлэхээр төслийг 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргад танилцуулаад байна.

2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 нэгдсэн арга хэмжээ /улсын хэмжээнд зохион байгуулсан 12, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар,

хэлтсээс зохион байгуулсан 28/, 75 хэсэгчилсэн арга хэмжээ, 188 удаа нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагддаг томоохон баярыг гэмт хэрэг зөрчилгүй тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Сар шинэ-2017” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 2017 оны 02 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдөр хүртэл зохион байгуулав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй болон түдгэлзүүлсэн хэргүүдийг нөхөн илрүүлэх, оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж баривчлах, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сар шинэ”, “Төгсөлт”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг таслан зогсооё”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Нийтийн тээвэр хамгаалах бүс” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудас, танилцуулгыг цаг тухай бүрт нь холбогдох газарт нь хүргүүлж дүгнүүлэв.

Мөн Ерөнхий боловсролын сургуулиудын зуны амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийн зуслангуудын үйл ажиллагаанд хяналт тавих, амарч байгаа хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Зуслан” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл зохион байгуулж, үр дүнгийн талаарх илтгэх хуудсыг УСХэлтэст хүргүүлж дүгнүүлэв.

Их дээд сургуулиудын 2017-2018 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан оюутан, сурагч, багачуудыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг, эх асран хамгаалагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Хичээлийн шинэ жил-замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж, үр дүнгийн илтгэх хуудсыг хүргүүлэн ажилласан.

Эрүү, хэв журмын нөхцөл байдлын сар бүрийн мэдээнд үндэслэн цагдаагийн газрын криминологи судалгааны баг тогтмол хуралдаж, гэмт хэрэг, зөрчил дийлэнх гардаг Арвайхээр сумын багуудад тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “ЗАХ”, “РС-1,2,3”, “SCHOOL POLICE-1,2”, “ХӨРШ АЙЛ”, “ХӨРШ АЙЛ-2”, “БАГ АЮУЛГҮЙ ОРЧИН”, “ЗАХИРГААНЫ ХЯНАЛТ”, “ХАМГААЛАХ БҮС”, “СОГТУУ”, “НИЙТИЙН ТЭЭВЭР”, “ХУРД”, “ХОТ ХООРОНДЫН ХЯНАЛТ”, “СОГТУУ”, “БАГ” “МОТОЦИКЛЬ”, “ИРГЭН ТАНЫ ТӨЛӨӨ”, “ГОЛ”, “ОЙ ХЭЭР”, “СЭРГЭЭН ШИЙДВЭРЛЭЛТ”, “ХАМГААЛАХ МАЛГАЙ”, “ТЭЭВЭР”, “СОГТУУГААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХЫГ ТАСЛАН ЗОГСООЕ”, “ТУСГАЙ ДУУТ ГЭРЭЛ ДОХИО”, “НИЙТИЙН ТЭЭВЭР ХАМГААЛАХ БҮС” гэх мэт нийт 75 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд нийт гэмт хэргийн гаралт 0.6 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 29.7 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтүүд харагдаж байна.

Цагдаагийн газраас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах нэг сарын аян”-ны төлөвлөгөөг ЦЕГ-ын тэргүүн дэд даргаар батлуулан ирүүлсэний дагуу, 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн танилцуулгыг хүргүүлсэн.

Аяны ажлын хүрээнд Олон улсын гэр бүлийн өдрийг угтаж Дэлхийн зөн Өвөрхангай орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Бусдыг өөрийн адил хайрлацгаая” уриан дор “Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчье” challenge-ийг эхлүүлсэн.

Видео challenge-д Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчит 53 байгууллага, аж ахуй нэгжийг нэгтгэсэн.

Хүчирхийллийн эсрэг “ногоон” өнгө, бусдын зүрхийг хайрлаж, хүүхэд бүрийг хүчирхийлэлгүй, аюулгүй орчинд өсөж, хөгжих боломжийг олгоход бусдыг уриалах зорилго бүхий “Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчье” challenge хоногт 1000 гаруй

иргэдийн хандалттай байж иргэдэд хууль сурталчилах зорилгоо биелүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилах “Амар тайван гэр бүл” дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.

Тэмцээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 байгууллагын 44 төрийн албан хаагч оролцож, 1, 2-р байр эзэлсэн багийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс шагнаж урамшуулсан.

“Аймгийн засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 02 албан даалгаврийн хүрээнд нийт сумдын алба хаагч нарт зөвлөмж хүргүүлж, Аймгийн татварын хэлтэстэй хамтран удирдамж гарган сумдын алба хаагч нарт албан даалгаврыг хэрэгжүүлэх Засаг даргаараа захирамж гаргуулан ажлын хэсэг байгуулж бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөр торгуулиад торгуулиа төлөөгүй иргэдийн судалгааг сум орон нутаг, баг хороодоор нь гаргаж төлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар үүрэг өгч биелэлтийг тооцон ажиллаж байна

Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаа: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа 315, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага 119, өдөрлөг 27, уралдаан, тэмцээн 37, нийт 418 удаа зохион байгуулж, 81553 иргэнийг хамруулсан байна.

Энэ арга хэмжээг агуулгаар нь авч үзвэл: Нийт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, хулгайлах гэмт хэргийн талаар 49, бусдын биед гэмтэл учруулах /танхайрах/ гэмт хэргийн талаар 6, залилан мэхлэх гэмт хэргийн талаар 3, зам тээврийн осол хэргийн талаар 21, гэр бүлийн хүчирхийллийн талаар 71, хүүхдийн гэмт хэргийн талаар 78, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр 88, хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаар 3, хүн худалдаалах гэмт хэргийн талаар 1, цахим гэмт хэргийн талаар 1 удаа ухуулга, яриа, сургалт сурталчилгаа зохион байгуулжээ.

Тухайлбал: Монголын Хуульчдын холбооны Өвөрхангай аймаг дахь Салбар байгуулагдсаны 1 жилийн ойг тохиолдуулан тус салбараас санаачлан “Хуульчдын өдөрлөг” нэртэйгээр “Хуулийн байгууллагуудын нэгдсэн нээлттэй хаалганы өдөр”-өөр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, цагдаагийн мэргэжлийн албадын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн байгууллагуудын 10 байгууллагын төлөөлөл оролцсон өргөн хүрээтэй арга хэмжээ болж, тус газрын үйл ажиллагааны талаар болон цагдаагийн албанд анх орон иргэнд тавигдах шаардлага, хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцааны талаар 85 иргэнд мэдээлэл өгч, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 төрлийн гарын авлага, боршур бэлтгэн 4500 гаруй иргэдэд тараан ажилласан.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн теле хяналтын камерын систем нь Арвайхээр сумын нутаг дэвсгэрийн 30 хувийг нь хамардаг. Нийт 80 ширхэг камертайгаас 6 ширхэг нь авто машины дугаар таних, 12 ширхэг PTZ 360 градус эргэдэг, 300 метр газар татах боломжтой, хөдөлгөөнт камер, 62 ширхэг нь чиглэлтэй камер ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн “Теле-хяналтын камер”-ийг өргөтгөх чиглэлээр хамтран судалгаа, тооцоог гаргаж танилцуулгыг аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдын хурлын дарга, Хууль эрх зүйн хэлтсийн даргад хүргүүлж одоо ашиглагдаж байгаа Арвайхээр сумын төв зам, гудамж талбайд 80 ширхэг камер суурилуулан ажиллуулж байгаагаас нэг чиглэлийн 62 камер, хөдөлгөөнт 12 камер, автомашины улсын дугаар таних 6 камер дээр нэмэж шаардлагатай 23 цэгийн 41 хяналтын камер суурилуулахаар 642.8 сая төгрөгийг

шийдвэрлүүлж 2018 онд үе шаттай хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Өмнөх онд аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хяналтын камер-1, 2” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд 278 аж ахуй нэгж байгууллагыг өөрсдийнх нь хөрөнгөөр хяналтын камер суурилуулсан. Энэхүү ажлыг цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр 2017 оны 1 дүгээр улиралд согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудад тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах болон шинээр олгохдоо цагдаагийн газраас хяналтын телекамер суурилуулсан эсэхэд сум, баг хариуцсан хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нараас дүгнэлт гарган шийдвэрлэдэг болсоноор өнөөдрийн байдлаар согтууруулах ундааны 542 цэгийн 2685 камержуулаад байна.

Тус газраас 2017 оны жилийн эцэст гудамж талбай, байгууллага аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэгүүдийн камержуулалтыг 80 хувьд хүргэхээр зорилго тавьж, мэдэгдэл шаардлага хүргүүлж, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

2017 онд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах тухай хууль болон журам зөрчсөн 359 зөрчлийг илрүүлж холбогдох албан тушаалтанд нь бүртгэл, баримтаар хүлээлгэн өгч захиргааны арга хэмжээ оногдуулах мэдэгдэх хуудсаар хэвлэж, танилцуулж хэвшсэн. Цагдаагийн алба хаагчаас камерийн бичлэгийг хулгайн гомдол, мэдээллийн дагуу 75 удаа, мотоциклийн хулгайн чиглэлээр 10 удаа, замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн ослын чиглэлээр 34 удаа нөхөн шүүлгэснээс 80 хувийг нь камерийн тусламжтайгаар илрүүлээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ: Хэлтэс, тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нараас 2017 онд гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй үндэслэлээр 40 этгээдийг “Судалгаа хяналтын сан”-д бүртгэсэн байна. Энэ төрлийн судалгааг тогтмол баяжуулж байх талаар сумдын Хэлтэс, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, цагдаа нарт Цагдаагийн газрын даргын 45/446 дугаартай ажлын чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Судалгаанд авагдсан этгээдүүдийн 53 нь хулгайлах, 24 нь бусдын биед гэмтэл учруулах /танхайрах/, 9 танхайрах, 14 нь гэр бүлийн хүчирхийлэл, 18 нь байнга архидан согтуурдаг, 24 зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэх бүртгэлээр судалдаанд авагдсан.

Бүртгэгдсэн иргэдийн 40 иргэнтэй ганцаарчлан уулзаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийж, зөвлөгөө өгсөн.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр явуулсан ухуулга, сурталчилгаа:
Телевизээр: Цагдаагийн газраас 2017 оны 04 дүгээр улиралд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 209 удаа, 9 цаг, 2 минутын хугацаатай нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг орон нутгийн “Арвайхээр чөлөөт суваг”, “Дөлгөөн-Соёмбо”, “Хас”, “GM”, улсын чанартай ТВ-9 инфо”, “Молор” телевизүүдээр явуулж, 258 удаагийн давталттайгаар иргэд олон нийтэд хүргэсэн.

Радиоогоор: Ноён-Уул FM 102.6 радио, Авто радио FM -93.68 зэрэг радио FM-ээр нийт 38 удаа, 1 цаг 15 минутын хугацаатай ухуулга, сурталчилгааг 42 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн.

Цахим хуудсаар: Нийт 147 мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэгийг цагдаагийн газрын пэйж хуудас, вэйб сайт, www.police.gov.mn, [www.tsagdaa.ukh.@gmail.com](mailto:www.tsagdaa.ukh@gmail.com) цахим хуудас болон олон нийтийн сүлжээ хуудсуудад байршуулсаныг давхардсан тоогоор 211798 орчим иргэд, олон нийтэд хүргэсэн.

“Өвөрхангайн элч”, “Өвөрхангайн өнгө”, зэрэг сонин, сэтгүүлд 41 мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтэлсэн.

Гурав. Алба хаагчийн ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн

шаардлагыг хангаж ажиллах

2017 онд шинээр томилогдсон 21 алба хаагчтай “Хариуцлагын гэрээ” байгуулж, байгууллагын “Дотоод журам”-ыг зөрчихгүй ажиллах талаар баталгаа авав. Цагдаагийн газарт 2017 онд 46 албаны шалгалт явуулж, 66 алба хаагч холбогдсон байна. Үүнээс офицер 43, ахлагч 23 байна.

Иргэд, аж ахуй нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 20, дотоодын хяналт шалгалтаар 23 албаны шалгалт явуулснаас хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн 8, эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан 1, хэрэг материал дутуу шалгасан 1, цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 7, ажлын хариуцлага алдсан 3, архидан согтуурсан 6, ЭБШХ /ЭХХШТХ/ болон бусад хууль дүрэм зөрчсөн 8, үүрэг даалгавар үл биелүүлсэн 1, ажил тасалсан 6, торгуулийн тасалбар үрэгдүүлсэн 4, бусад 1 зөрчил гаргасан байна.

Албан тушаалын хувьд тасаг, хэсгийн дарга 4, мөрдөгч 4, ахлах мөрдөгч 2, эрүү эдийн засгийн төлөөлөгч 24 хэсгийн төлөөлөгч 12, хэв журмын офицер 11, замын цагдаагийн ахлах байцаагч 2, бусад офицер 2, эргүүлийн цагдаа 2, цагдаа-зохицуулагч 4, цагдаа жолооч 2, бусад цагдаа 12, бусад 3, боловсролын хувьд дээд боловсролтой 57, бүрэн дунд 9, ажилласан жилийн хувьд 1-5 жил ажилласан 19, 6-10 жил ажилласан 24, 11-15 жил ажилласан 15, 16-20 жил ажилласан 4, 21-25 жил ажилласан 2 байна.

Сахилга ёс зүйн зөрчлийг байгууллагын дотоод хяналтаар 23, ёс журмын хяналтаар 4, гадны хяналтаар 3, иргэд байгууллагын мэдээллээр 16-г илрүүлж, 34 алба хаагчийн цалинг бууруулсан, ажил албанаас халсан 1, сануулсан 6, нотлогдоогүй 14, нотлогдсон боловч хуулийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан 2, хугацаатай үүрэг даалгавар өгсөн 9 байна. ЦЕГ-ын даргын зөвлөлийн шийдвэрийг тухай бүр бие бүрэлдэхүүнд танилцуулж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 21 удаа хийж, холбогдох асуудлыг шийдвэрлэв. Газрын даргын тушаал боловсруулах батлуулах үйл ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хяналтын хувийн хэрэг нээж бүрдүүлэлтийг хийн ажиллаж байгаа бөгөөд энэ онд албанаас дутагдлаар халагдсан нэг алба хаагч аймгийн Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж маргаан үүсгэсэн боловч газрын даргын тушаал үндэслэлтэй болох нь тогтоогдов.

Цагдаагийн газрын хэмжээнд “Цагдаагийн алба хаагчийн харицааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2016 онд 3 гэмт хэрэгт 5 албан хаагч холбогдож 30 албан хаагч сахилгын арга хэмжээ тооцогдсон бол 2017 онд 1 гэмт хэрэгт 1 алба хаагч холбогдон шалгагдаж, 30 офицер, 12 ахлагч нийт 42 алба хаагч сахилга ёс зүйн зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд албан тушаалын байдлаар авч үзвэл хэлтсийн дарга 2, хэсэг, тасгийн дарга 3, эрүү, эдийн засгийн мөрдөгч-2, ахлах мөрдөгч-2, мөрдөгч-3, хэв журмын офицер-1, хэсгийн төлөөлөгч-5, хэсгийн байцаагч-1, замны цагдаагийн ахлах зохицуулагч-2, бусад офицер-9, хэв журмын цагдаа-6, эргүүлийн цагдаа-3, цагдаа-зохицуулагч-1, бусад-2, зөрчлөөр нь авч үзвэл ажлын хариуцлага алдсан 3, архидан согтуурсан 6, ЭБШХ /ЭХХШТХ/ зөрчсөн 6, бусад хууль тогтомж зөрчсөн 6, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 7, үүрэг даалгавар үл биелүүлсэн 3, бусад 11, үүнээс сахилгын шийтгэлийг байгууллагын даргын тушаалаар 38, цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 4 алба хаагч хүлээсэн.

Дээрх 42 зөрчлийн 34 буюу 75 хувийг байгууллагын дотоод хяналтаар илрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс /2016 онд 30 зөрчил гарсаны 21 буюу 70 хувийг дотоод хяналтаар илрүүлсэн/ 10,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын тоо өмнөх оны мөн үеэс 12-оор өссөн байгаа нь байгууллагын дотоод хяналт шалгалт сайжирч зөрчил илрүүлэлт сайн байгаа нь харагдаж байна. Алба хаагчдаас албан тушаал /ажлын байр/-тай холбоотой хууль дүрмийг судладаггүй,

хуулийг зөв хэрэглэх мэдлэг дутмаг, албаны бэлэн байдлыг хангаж ажилладаггүй, удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлдэггүй, хэрэг, зөрчил шалгахдаа процессын зөрчил гаргадаг дутагдлууд түгээмэл ажиглагдаж байна.

Цаашид хэлтэс, тасаг, хэсгийн дарга нар алба хаагч нэг бүртэй тулж ажиллах, албан хаагчдыг сурган дадлагажуулах төлөвлөгөөний дагуу үр дүнтэй ажил зохион байгуулах, хийсэн ажлыг нь дүгнэж байх, сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагчдыг ЦЕГ-ын сургалтын нэгдсэн төвд ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулах, алба хаагчид өөрсдийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллахад онцгой анхаарах шаардлагатай байгаа талаар сахилгын зөвлөгөөнөөс шийдвэр гаргасан.

Сахилгын зөрчил гаргасан болон давтан гаргасан алба хаагч нартай болон тэдний гэр бүлийн гишүүдтэй сэтгэл зүйч ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж, сахилгын зөрчил гаргах болсон шалтгаан нөхцлийн талаар судалж, байгууллагын удирдлагад танилцуулж, зөрчил гаргасан 12 алба хаагчийг ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулав. Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч нарт “Итгэл найдварын хуудас” гардуулан өгч, баталгаа гаргуулан авч ажиллалаа.

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр “Оюунлаг цагдаа” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчдаас байгууллагадаа ном хандивлах аяныг зохион байгуулж, дүгнэв.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагч бүрт тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудаас хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу алба хаагч тус бүртэй ажиллаж, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлаж, 3 хэсгийн төлөөлөгчийн ар гэрийн холбогдох хүмүүстэй уулзаж, сум орон нутгийн удирдлагаас хэрхэн ажил үүрэг гүйцэтгэж байгаа талаар, сар бүр цагийн тооцоог гаргуулан авч, бусад алба хаагчдын хувьд тасгийн дарга ахлах албан тушаалтан, бусад тасаг, хэсгийн зүгээс хамтран ажиллах, сэтгэл зүйчээс гаргасан төлөвлөгөөний хүрээнд сэтгэл зүйн тандалт судалгаа явуулж тодорхой ажил, сургалтыг зохион байгуулж байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдаас 12 алба хаагчийн ёс зүйн төлбөртэй сургалтад ЦЕГ-ын Сургалт дадлагын төвд хамруулаад байна.

Сахилгын зөвлөгөөнийг алба хаагчдын дунд улирал тутам зохион байгуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдын эерэг таатай уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Гэр бүл үнэ цэнэ 2017” сургалт зөвлөгөөнийг алба хаагчдын гэрийн бүлийн дунд Тарагт сумын “Өгөөмөр” амралтын газарт зохион байгуулж, алба хаагчид гэр бүлийн хамт “Эх үрсийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлсэн нь олны талархалыг хүлээсэн чухал ажил арга хэмжээ болсон.

Аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл шалгалтыг эрчимжүүлэн, эргүүл шалгалтанд гарч буй алба хаагч нарт тавих хяналтыг сайжруулан томилгоот дарга, ёс журам сахиулах эргүүлийг ажиллуулж, үйл ажиллагааг зурагжуулан баримтжуулах зорилгоор өдөр бүр алба хаагчийг томилон сурвалжлагч ажиллуулж байна.

Алба хаагч нарын мэдээ өгөх байдлыг нэгдсэн системд оруулан, чиглэл чиглэлээр хаалттай Facebook групп нээж алба хаагч нарт хариуцуулан мэдээг авч Facebook групп-т байршуулан, алба хаагч нарыг А-Ф үнэлгээгээр үнэлэж дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна

Аймгийн Засаг дарга, ЦЕГ-ын Ахмадын хороотой хамтран тус байгууллагаас төрөн гарсан Монгол улсын гавьяат цолтон, төв орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, “Ахмад дунд залуу үеийн уулзалт зөвлөгөөн”-ийг 09 дүгээр сарын 20-оос 23-ны өдрүүдэд цагдаагийн газарт зохион байгуулав.

Цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчидын сахилга хариуцлагын талаарх мэдээллийг Цагдаагийн газрын вэб сайтад байрлуулж, алба хаагчид болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг Засаг даргын дэргэдэх Шуурхай удирдлагын төвийн 70321111, цагдаагийн газрын 7032102, 70322691 тоот утсаар хүлээн авч ажиллаж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг түргэн шуурхай иргэдэд хүртээмжтэй байлгах, цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор өдрийн дуудлагын цагдааг хөтөч цагдаагийн үүргийг давхар гүйцэтгүүлж байна. Алба хаагчдын харилцааны соёл ёс зүйг сайжруулах чиглэлээр 4 удаа сургалт зохион байгуулсан бөгөөд сар бүр ажил дүгнэхэд сахилга ёс зүйн байдлыг харгалзах үзүүлэлт болгож байна.

ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан мэргэшүүлэх болон давтан сургалтанд 58 алба хаагч, удирдлагын сургалтад 2, Удирдлагын академийн төрийн удирдлагын сургалтад 3, офицер албан тушаалын сургалтад 2, гадаадад 2, магистрантурт 2, эчнээд 11, мөрч нохойн сургалтанд 1 алба хаагч, эрсдэлийн удирдлагын чиглэлээр хийгдсэн сургалтанд 4 алба хаагч, Төв архивын газраас зохион байгуулсан сургалтанд 2 алба хаагч тус тус хамрагдсан байна.

Байгууллага алба хаагчийн үйл ажиллагаанд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Ажил үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлж, хэвшүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг сар бүр газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж үнэлэлт дүгнэлт өгч байна. Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын цугларалтаар “Гэр бүлийн хүчирхийлэлийн хор уршиг”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчидод үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Аюулгүйн зэргийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт” сэдвээр болон “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх” дэд хөтөлбөрөөр 2 цагийн сургалтыг 2 удаа зохион явуулав

Дөрөв. Санхүү, хангамжийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

2017 онд улсын төсвөөс 1879399.3 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, өөрийн орлогын төлөвлөгөө 57326.0 мянган төгрөг нийт 1936725.3 мянган төгрөг зарцуулах эрхтэй үүрэг гүйцэтгэснээс зардлын гүйцэтгэл 100% байна. Үүнд: цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 1567492.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 33674.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 70042.5 мянган төгрөг, хангамж, материалын зардалд 117946.1 мянган төгрөг, нормативт зардалд 34909.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 35860.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 22160.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 15499.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, засаг даргын нөөц хөрөнгөөс нийтдээ 122376.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 16312.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2747.8 мянган төгрөг, нийт 141445.8 мянган төгрөгийг хүлээн авч бүртгэлд тусган, холбогдох зардлуудад зарцуулсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0 төгрөг, бараа материалын үлдэгдэл 145671.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 927843.6 мянган төгрөг байна.

ЦЕГ, Орон нутгийн өмчийн газар, Засаг даргын захирамжаар 94868,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч, бүртгэлд тусган, 42839.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зарлагдаж, данснаас хассан.

2017 онд хэмнэгдэх боломжтой зардлаас өглөг үүсээд байгаа зардалд Засгийн газрын 2013 оны 73 дугаар тогтоолын дагуу төсөвт зохицуулалт хийлгэх тухай 3 албан

бичгийг зардлын судалгааны хамт ЦЕГ-ын Санхүү аж ахуйн албанд хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Сумдын хэсгийн төлөөлөгч нарын гэрэл цахилгаан, шатахууны зардалд лимит тогтоосон цагдаагийн газрын даргын тушаал гарган, тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн хэсгийн төлөөлөгч, цагдаа нар, сумдын цагдаагийн хэсэг тасгийн алба хаагч нарт цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг албан бичгээр тогтмол хүргүүлж танилцуулж байна.

Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан кобан байрны судалгаа гарган Санхүү хангамжийн газар хүргүүлсэн бөгөөд Хайрхандулаан, Уянга сумын цагдаагийн кабон байрны их засварын ажил хийлгэх талаар зардлын төсвийг Санхүү хангамжийн газарт 2016 оны 12 сарын 22 өдөр 41/512 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хайрхандулаан сумын кобан байрыг их засварын ажлыг 7.2 сая төгрөгөөр 2017 оны 05 сарын 23-ны өдрөөс 06 сарын 05 өдрүүдэд хийж ашиглалтад оруулсан. Уянга сумын цагдаагийн хэсгийн кобан байрыг сумын төвийн дулааны шугамд холбож, 1.650.000 төгрөгийн урсгал засварыг хийж хэвийн байдалд оруулж ажилласан. Мөн цагдаагийн газрын мөрдөн байцаалтын 2 өрөөнд 9 сая бүрэн засвар үйлчилгээ хийж ашиглалтанд оруулж хэвийн ажиллагаанд оруулсан байна. Сумдын кабон байр өөрийн нөөц бололцоогоор өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд засвар үйлчилгээ хийж ажилласан.

2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллийг боловсруулж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЦЕГ-ын санхүү аж ахуйн албанд хүргүүлсэн. Төсвийн төсөлд зардал тус бүрийн нэг бүрчилсэн судалгааг хийж тусгасан болно.

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжсэн орлого болон зардлын зарцуулалтыг байгууллага дотор Санхүүгийн ил тод байдал нэртэй самбар ажлуудан алба хаагчид болон иргэдийг санхүүгийн мэдээллээр байнга ханган ажиллаж байна. Самбарт 2016 онд Засгийн газар, Сангийн яамны тогтоол, тушаал, шийдвэр, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын захирамж нийт 5 мэдээлэл, төлбөр хураамжтай холбоотой шийдвэр 1 мэдээлэл, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн судалгаа 12 мэдээлэл, 2017 оны батлагдсан төсвийн хуваарийг тус тус оруулж мэдээлсэн. Шилэн дансны нэгдсэн системд хуульд заасан хугацаа, хуваарийн дагуу 2017 оны төсвийн төсөл 1 мэдээлэл, Төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан 12 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээ 48 мэдээлэл, 5.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, байгууллагын орон тоонд орсон өөрчлөлтийн 12 мэдээлэл, тус тус оруулсан. Байгууллагын "Uvurkhangai.police.gov.mn" сайтаар шилэн дансанд тавьсан бүх мэдээллийг иргэд цахим сүлжээ хэрэглэгчдэд мэдээлж байна. Санхүүгийн ил тод байдал нэртэй мэдээллийн самбарыг байнга ажиллуулж мэдээллийг 7 хоног бүр шинэчилж, санхүүгийн сүүлийн үеийн мэдээлэл, холбогдох тушаал журам шийдвэр, төсвийн сарын мэдээ зэргийг байршуулсан. ЦЕГ-ын дэд дарга болон санхүү хангамжийн газраас ирүүлсэн шилэн дансны тухай мэдээлэл, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах тухай зөвлөмж, ажлын чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тав. Алба хаагчдын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр

Алба хаагчдын дунд "Аз жаргалтай өдөр" арга хэмжээг эхлүүлж төрсөн өдөр нь тохиосон алба хаагчдад баяр хүргэж мэндчилгээ гардуулж байгаа ба хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Цагдаагийн газрын <http://Uvurkhangai.police.gov.mn> цахим сайтад мэдээлэл оруулж, мөн tsagdaa.ukh@gmail.com- хуудасд шинээр мэдээлэл шинэчлэн оруулсан байна. "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр", "Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр",

"Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган сумдын хэлтэс тасаг, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. "Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн Зонноз судлалын төвтэй хамтран алба хаагчдыг тарваган тахалын вакцинд хамруулсан. Мөн "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас Цагдаагийн газарт ажиллаж байгаа 40-өөс дээш насны алба хаагчдыг элэгний В, С вирусын үзлэг, шинжилгээнд хамруулсан.

Цагдаагийн газраас Монголын Цагдаагийн байгууллагын түүхт 96 жилийн ой, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар байгуулагдсаны 78 жилийн ойн баярын арга хэмжээг "Олон дов" амралтын газар зохион байгуулж, ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж байгаа алба хаагчдыг шагнаж урамшуулсан. Аймгийн Засаг даргын "Хөрөнгө акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх тухай А/328 захирамжаар Сумдын Эрүүл мэндийн төвүүдээс актласан автомашинуудыг хүлээн авч 2017 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэсгийн төлөөлөгч нарт хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ зохион байгуулсан ба уг арга хэмжээнд ахмад ажилтнуудаа урьж оролцуулсан.

Цагдаагийн газрын хэмжээнд нийт 39 ахмад настан харьяалагдаж байгаа бөгөөд цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Бат-Очирыг төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Содномцэрэнг "Алтан гадас" одонгоор цагдаагийн бэлтгэл ахмад С.Александр, цагдаагийн бэлтгэл ахмад Б.Готовсүрэн нарыг "Цэргийн хүндэт медаль"-аар шагнуулах санал, тодорхойлолтыг аймгийн ИТХТ-ийн даргын нэр дээр албан бичгээр хүргүүлэв. Цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Бат-Очирыг ЦЕГ-ын "Цагдаагийн төлөө" тэмдэг, ЦЕГ-ын дэргэдэх Цагдаагийн ахмадын байгууллагын "Хүндэт тэмдэг"-ээр тус тус шагнуулсан.

Газрын алба хаагчдын санаачилгаар алба хаагчдын мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт зохион байгуулах "Хээрийн сургалт дадлагын төв" барих ажлыг зохион байгуулж Арвайхээр хотоос зүүн тийш 5 километр зайд 2 га газар авч тус бүр нь 7.5 сая төгрөгний өртөгтэй 5 ширхэг амралтын байр барьж цахилгаан, гүний худаг гаргуулан, хашааг барьж, дулааны асуудлыг шийдвэрлэв.

Тус аймгаас 2017 оныг "Ахмадыг дээдлэх жил" болгон зарласантай холбогдуулан Аймгийн Засаг дарга, ЦЕГ-ын Ахмадын хороотой хамтран тус байгууллагаас төрөн гарсан Монгол улсын гавьяат цолтон, төв орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, "Ахмад дунд залуу үеийн уулзалт зөвлөгөөн"-ийг 09 дүгээр сарын 20-оос 23-ны өдрүүдэд цагдаагийн газарт зохион байгуулав.

Зургаа. Дотоод хяналтын хүрээнд:

1.Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ үр дүн.

Цагдаагийн газраас 2017 онд зохион байгуулах дотоод хяналт шалгалтын удирдамж төлөвлөгөө, шалгалт явуулах сумдын хуваарь, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон тушаал боловсруулж батлуулан Хархорин сумын үйл ажиллагааг шалган зааварчилж, сумдад нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга томилолтоор ажиллаж камержуулалтын талаар судалгааг хийж сумдын удирдлагуудтай уузаж ажиллав.

Цахим программ хангамж бүхий нээлттэй үйлчилгээг нэвтрүүлж, олон нийттэй харилцах ахлах байцаагчид хариуцуулсан ба иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн

байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд хариуг өгч байна.

Байгууллагын “Цахим сан”-д тогтмол мэдээлэл оруулах, ажлын хэсгийг томилж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргэж байна. Цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд нээлттэй ил тод, шуурхай хүртээмжтэй ажил үйлчилгээг үзүүлэх зорилгоор uvurkhangai.police.gov.mn вэб сайтыг ажиллуулж, 2017 онд веб сайтад 75, цагдаагийн газрын page хуудсанд 72 мэдээллийг боловсруулан тавьж, иргэдэд сурталчилсан байна. 2017 оны 06 дугаар сарын 12-оос цагдаагийн газрын даргын шийдвэрээр байгууллагын томилгоот бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж “Сурвалжлагч алба хаагч” томилон цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг фото зургаар бэхжүүлэн танилцуулгыг байгууллагын хаалттай группэд тавьж нийт бүрэлдэхүүнд мэдээлэх ажлыг хэвшүүлж эхлээд байна.

2. Шүүх, прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ

Цагдаагийн газрын захиргааны журмаар албадан саатуулах үйл ажиллагааг шалгаад аймгийн Прокурорын газрын 03 дугаар сарын 15-ны өдрийн “Шалгалтаар илэрсэн зөрчлийг засуулах тухай” 01, Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн “Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ял нь тэнсэгдсэн ялтнуудын ял эдлэлтийн байлдалд цагдаагийн байгууллагаас хэрхэн хяналт тавьж байгаа эсэх” талаар шалгаад сум дундын прокурорын газраас ирүүлсэн “Шалгалтаар илэрсэн зөрчлийг засуулах тухай” 02 дугаар сарын 23-ны өдрийн 7/01 шаардлагуудыг хүлээн авч сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, буруутай алба хаагч нарт албан шалгалт хийгдэж хариуцлага тооцож хариуг тухай бүр хүргүүлэв. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр аймгийн Прокурорын газраас 2 шаардлага, арга хэмжээ тооцуулах тухай 3 албан бичиг хүлээн авч холбогдох алба хаагчид албаны шалгалт явуулж хариуцлага тооцож ажилласан.

Цагдаагийн газрын захиргааны журмаар албадан саатуулах үйл ажиллагааг шалгаад аймгийн Прокурорын газраас ирүүлсэн шаардлагыг хүлээн аваад зөрчлийг засах чиглэлээр дараах ажлыг хийж байна. Албадан саатуулах ажиллагааг хуулийн хүрээнд явуулах чиглэлээр жижүүрийн ахлах офицероос харьяа шүүхийн байгууллагын шүүгчид мэдэгдсэн бүртгэлд тулгалт хийн зөрчил гаргасан алба хаагчдад албаны шалгалт явуулж, ЦБҮАЖ-аар холбогдох алба хаагч нарт сургалт зохион байгуулж, зөрчил гаргахгүй ажиллах талаар баталгаа гаргуулж авав. Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсээс прокурорын шаардлагын мөрөөр үүрэгт шаардлагад нэр дурдагдсан 5 алба хаагчийн албан тушаалын цалинг 1 сарын хугацаагаар 10% хасаж хариуцлага тооцож сургалт зохион байгуулан ажиллаж байна. Прокурорын шаардлагад заагдсан зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар алба хаагчдаас баталгаа гаргуулан авч сургалт зохион байгуулж ажилласнаар шаардлагад заагдсан зөрчил дахин давтагдан гараагүй байна.

3. Цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн тухай өргөдөл, мэдээлэл, санал хүсэлтийг шийдвэрлэж буй байдал.

2017 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гэмт хэргийн шинжтэй 1956 гомдол, мэдээллийг хүлээн авч 906 гомдол, мэдээлэлд нь эрүүгийн хэрэг үүсгэн, 349 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал прокурорт хүргүүлж, бүх гомдол мэдээллийг 100% хуулийн хугацаанд нь шалгаж, гомдол мэдээлэл гаргагчид хариуг нь өгч ажилласан байна. Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 609 гомдол мэдээллийг буюу 67,2 %-ийг нь 5 хоногт 297 буюу 32,7%-ийг 5-19 хоногт шийдвэрлэсэн байна. Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол мэдээлэл

байхгүй байгаа бөгөөд долоо хоног бүрийн даваа гаригт газрын дарга гомдол мэдээллийн шийдвэрлэлтэнд биечлэн хяналт тавьж зөрчил гаргасан алба хаагч нарт зөвлөмж өгч биелэлтийг тооцож байна. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явц байдлыг 7 хоног тутмын 1 дэх өдөр бие бүрэлдэхүүнд танилцуулж, мэдээлэл хийн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар холбогдох үүрэг чиглэлийг өгч хэвшээд байна.

Энэ хугацаанд аймгийн прокурорын газрын ажилтнууд цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын өргөдөл гомдлыг шийдвэрлэх чиглэлээр хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж ажлын явц байдал, гарч буй зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хамтран ажилласны үр дүнд хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт сайжирч байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой гомдол, санал, хүсэлт нийт 31 ирсэнг хүлээн авч хэлтэс, тасгийн дарга нар албаны шалгалт явуулж даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэн хариуг гомдол гаргасан, иргэн аж ахуй нэгж байгууллагад хариуг өгч ажиллав.

Долоо. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар.

1. Сэргээн шалгаж байгаа эзэнгүй хэргийн нөхөн илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцох
2. Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг хөрш зэргэлдээ аймгийн болон бүсийн Цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулж, эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх
3. Цагдаагийн газрын сумд хариуцсан хэлтэс, тасаг, хэсгийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, орон нутагт ажиллаж буй алба хаагчдын ажлын үр дүнг сайжруулах
4. Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчийн тоо урьд оны мөн үеэс буурсан боловч таслан зогсоогдохгүй байгаад дүгнэлт хийж, алба хаагчдын сахилга, хариуцлага, удирдах болон ахлах ажилтнуудын шат дараалсан хяналтыг сайжруулж, манлайллыг дээшлүүлэх
5. Сургалтын төвийн бусад тохижилтын ажлыг хийж дуусгах.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН :

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,

ЦАГДААГИЙН АХМАД

Ч.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:

ДАРГА, ЦАГДААГИЙН

ХУРАНДАА

О.ГАНБАТ